

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2022 оны 12 дугаар сарын 25-ны өдөр

Тус байгууллага нь Засгийн газрын үйл ажиллагааны 2020-2024 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

**НЭГ. САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН  
ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:**

Иргэний нисэхийн багц дүрмийн шинэчлэлтэй холбогдуулан эдийн засгийн холбогдолтой дүрэм боловсруулах ажлын хүрээнд агаарын тээврийн эдийн засгийн зохицуулалтад тулгамдаж буй асуудал, ЗТХС-ын 2022 оны 4 дүгээр сарын 12-ны А/94 дугаар тушаалаар “ИНД-ийн нэр томъёоны тайлбар”-ыг батлуулж, 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдөр иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч нарт цахим шуудангаар хүргүүлэн, Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Зам тээврийн хөгжлийн яамны сайдын 2020 оны А/220 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/143 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор нийт 6 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, дараах 4 ИНД-ийг Зам тээврийн хөгжлийн яаманд батлуулахаар 2022 оны 9 дүгээр сарын 23-ны 01/1670 дугаар албан бичгээр хүргүүлсэн:

- ИНД-61-д “ганц нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд 60 нас, олон нисгэгчтэй үйл ажиллагааны хувьд 65 нас хүртэл үүрэг гүйцэтгэх”
- ИНД-67-д “60-аас дээш настай нисгэгчийн эрүүл мэндийн гэрчилгээний хугацааг 6 сар болгон багасгах”
- ИНД-119-д “25-аас дээш настай агаарын хөлгийг агаарын тээврийн зорчигч тээвэрлэх үйл ажиллагаанд ашиглахгүй байх”
- ИНД-47-д “20-оос дээш настай зорчигч тээврийн том агаарын хөлгийг Монгол Улсын бүртгэлд шинээр нэмж бүртгэхгүй байх” гэсэн шаардлагыг тус тус нэмэлтээр оруулсан.

**Зөвлөмжийн цувралын талаар:**

Англи хэл дээр 172 (үүнээс орчуулгатай 22) зөвлөмжийн цувралыг боловсруулж батлуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулан тогтмол шинэчлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд АС01-1, АС12-1, АС12-2-г шинэчлэн ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулсан. Мөн нийт 30 ЗЦ-ын (АС61-1, АС61-2, АС61-3, АС61-5, АС61-7, АС61-10, АС61-12, АС61-13, АС61-14, АС61-15, АС61-16, АС61-17, АС61-18, АС61-19, АС139-2, АС139-3, АС139-4, АС139-5, АС139-6, АС139-7, АС139-8, АС139-9, АС139-10, АС139-11, АС139-12, АС139-13, АС139-14, АС139-15, АС139-16, АС139-17) нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар батлуулахаар хүргүүлсэн.

Монгол хэлээр боловсруулсан нийт 22 Зөвлөмжийн цувралыг 2022 оны 4 дүгээр сарын 12-нд батлагдсан “ИНД-ийн нэр томъёоны тайлбар”-т нийцүүлэн Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулсан..

**Маягтын талаар:**

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 5 дугаар сарын 9-ний А/108 дугаар тушаалаар 24141-01 маягыг шинэчлэн батлуулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулсан.

Мөн ИНД-ийн шинэчлэлтэй холбоотойгоор нийт 9 маягыг шинээр (САА820, СА005i, 24021/22, 24061-31, 24067-216, 24077-01D, 24092/02, 24102-12, 24139-07) боловсруулж, 2022 оны 6 дугаар сарын 24-нд ИНЕГ-ын даргаар батлуулахаар хүргүүлсэн.

**Дүрмийн шаардлагаас чөлөөлөх талаар:**

Нислэгийн журам боловсруулалтын алба ИНД-173.69 “Аюулгүй байдлын удирдлага”, Нислэгийн цаг уурын төв ИНД-174.77 “Аюулгүй байдлын удирдлага” болон Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба ИНД-175.67 “Аюулгүй байдлын удирдлага”-ын шаардлагаас тус тус чөлөөлүүлж, SMS-ийн хэрэгжилтийн хугацааг 2023 оны 2 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 1 жилээр сунгуулах хүсэлтийг хүлээн авч холбогдох журмын дагуу Зам тээврийн хөгжлийн яаманд батлуулахаар



хүргүүлэхэд Иргэний нисэхийн ерөнхий газрын, Аюулгүй ажиллагааны зөвлөлийн шийдвэр хүлээгдэж байна.

Мөн МИАТ компанийн 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 0/1796 дугаар албан бичиг болон “Изинис Эйрвэйс”-ийн 2022 оны 5 дугаар сарын 20-ны 01/204 дүгээр албан бичгээр ирүүлсэн ИНД-131.19(з)-д “Монгол Улсад түрээсээр ашиглах агаарын хөлөг нь үйлдвэрлэгдсэнээс хойш 15 жилээс хэтрээгүй байх...” гэсэн шаардлагаас чөлөөлүүлэхээр дараах хүсэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 09-нд ИНЕГ-ын Аюулгүй ажиллагааны зөвлөлийн хуралд оруулахаар хүргүүлсэн бөгөөд хурлын тов хүлээгдэж байна.

Аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны (SMS) хэрэгжүүлэлт иргэний нисэхийн салбарт бүхэлдээ удаашралтай байгаа тул хэрэгжүүлэлтийн хугацааг 2 жилээр сунгахтай холбоотойгоор холбогдох байгууллагаас ирүүлсэн дүрмийн шаардлагаас чөлөөлүүлэх хүсэлтийг үндэслэн ИНД-115, ИНД-119, ИНД-137, ИНД-141, ИНД-145, ИНД-146, ИНД-147, ИНД-148, ИНД-139, ИНД-171, ИНД-172, ИНД-173, ИНД-174, ИНД-175-д орох өөрчлөлтийн төслийг бэлтгэсэн.

#### ***ИНД-ийг сурталчлан таниулах талаар:***

Нийт 4 зурагт хуудас (“Operating Within The Mongolian Civil Aviation Rules”, “ICAO guidance related to operational procedures to support the development of inspector guides”, “Civil Aviation Activity”, “Transition altitude and level”) болон;

Нийт 23 танилцуулга (“Commercial operation - NZ, EASA, FAA wording difference”, “Comparison of practical experience requirement for issue of licence (AMEL)”, “Иргэний нисэхийн нэр томьёог баримт бичигт тусгасан байдал”, “NZ Part 19 reference to MCAR”, “Transition level”, “Хүчингүй болгох шаардлагатай дүрмүүдийн талаар”, “Altitude, height, level, elevation”, “MCAR and NZCAR’s revision cross-reference”, “Иргэний нисэхийн тухай хуулийн алдаатай заалт”, “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журмын алдаатай нэр томьёо”, “Агаарын тээврийг хялбаршуулах журмын алдаатай нэр томьёо”) бэлтгэж, иргэний нисэхийн хэрэглэгчдэд цахим шуудангаар хүргүүлэн, Иргэний нисэхийн ерөнхий газрын цахим хуудсанд байршуулсан.

#### **ХОЁР. АГААРЫН ТЭЭВРИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай 2010 оны Бээжингийн конвенц”, “Агаарын хөлөгт үйлдсэн гэмт хэрэг, бусад зарим үйлдлийн тухай 1963 оны Конвенцод нэмэлт өөрчлөлт оруулсан 2014 оны Монреалийн Протокол”, “Бээжин хотноо 2010 онд батлагдсан Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай 1970 оны “Гаагын конвенцын нэмэлт протокол”-уудын баталгаат орчуулга, танилцуулга боловсруулан 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр ИНЕГ-ын цахим хуудсанд байршуулан санал авч, үзэл баримтлал, хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн үнэлгээ, хуулийн төсөлд зардлын тооцоо хийсэн тайланг тус тус боловсруулж 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 01/531 дүгээр албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Монгол Улсыг хөгжүүлэх 2023 оны саналд Иргэний нисэхийн ерөнхий газрын танилцуулга, короновирусийн /Ковид-19/ үр нөлөөний судалгаа, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын газрын саналыг Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн. Захиргаа, удирдлагын газраас Иргэний нисэхийн ерөнхий газрын саналыг нэгтгэн 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/95 дугаар албан бичгээр Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 1,2,3,4 дүгээр хавсралтуудаар батлагдсан аргачлалд нийцүүлэн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлд “орон нутгийн нислэгийн үйлчилгээ болон нисэх буудлын үйлчилгээ” гэсэн агуулгаар хуульд нэмэлт оруулахаар хуулийн төслийн үзэл баримтлал болон холбогдох судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцооллыг боловсруулж дуусган удирдлагад танилцуулж, тус хуулийн дагуу “хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах” гэх заалтын дагуу дотоодын агаарын тээвэрлэгчидтэй 2022 оны 01 дүгээр сарын 10-ний өдөр цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох саналыг авч Иргэний нисэхийн ерөнхий газрын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/133 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарт авлигын индексийг бууруулах талаар авах арга хэмжээний төлөвлөгөө”-нд “тийз олголтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэд мэдээлэл авах боломж бүрдүүлэх” гэж тусгасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, тийз захиалга, борлуулалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн эсэх талаар судалгаа дүгнэлт боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 01/389 дүгээр албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

“Орон нутгийн агаарын тээврийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан үйл ажиллагааг үр ашигтай болгох, орон нутгийн нисэх буудлуудын цаашдын ашиглалтын тухай” судалгааг 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 01/752 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

“Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээний 26.2.2-т заасны дагуу Концессын төлбөрийн хувь хэмжээг тогтоохтой холбоотойгоор орон нутгийн чиглэлд тээвэрлэсэн зорчигчдын тоог Иргэний нисэхийн ерөнхий газрын болон “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК тооцоо нийлэх зорилгоор гэрээний төлбөрийн хэмжээг тогтоохоор “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК -тай орон нутгийн чиглэлд 2021 онд тээвэрлэсэн зорчигчдын тоог дотоодын агаарын тээвэрлэгчдийн орон нутгийн чиглэлд тээвэрлэсэн зорчигчийн тоотой харьцуулан тооцоо нийлэх ажлыг 2, 3 дугаар саруудад зохион байгуулсан.

“Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх Концессын гэрээний дагуу 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр ирүүлсэн “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” ХХК-ийн 2021 оны санхүүгийн аудитаар орсон тайланд дүн шинжилгээ хийж, холбогдох судалгааг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 01/492 дугаар албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

“Изинис Эйрвэйз” ХХК-ийн АТ-026 дугаартай агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хугацааг сунгах үзлэг шалгалтын ажлын хүрээнд тус газарт “Изинис Эйрвэйз” ХХК-аас 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/031 дүгээр албан бичгээр үйл ажиллагааны танилцуулга, ИНД-303-ийн дагуу хийгдсэн даатгалын гэрээний гэрчилгээ, 2020, 2021 оны санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд, 2022 оны төлөвлөгөөг тус тус ирүүлсэн. Дээрх мэдээллүүдийг үндэслэн дүгнэлт гаргахад шаардлагатай нэмэлт мэдээллүүдийг авахаар цахим шуудангаар хүсэлт хүргүүлж, санхүүгийн тайланд тусгагдсан нислэг техникийн үйл ажиллагаа, ажилтнуудын шаардлагатай сургалт, тээврийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах хөрөнгийг санхүүжүүлэх чадамжтай эсэх талаар нэмэлт тодруулга авч мэдээлэлд үндэслэн холбогдох дүгнэлтийг гарган, Нисэхийн аюулгүй ажиллагааны, хяналт зохицуулалтын албанд 01 дүгээр сард хүргүүлсэн.

Хуваарьт нислэгийн чиглэл, тариф болон ерөнхий зориулалтын нислэг, зочид буудал, жуулчны баазын захиалга, аяллын мэдээлэл бүхий нэгдсэн захиалгын платформ бий болгох талаар судалгааг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/1855 дугаар албан бичгээр Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

#### ***Үнэ тариф, хураамж тогтоох чиглэлээр хийсэн хяналт, зохицуулалт, судалгаа:***

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанаас бэлтгэн гаргадаг бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэлгээг шинэчлэн тогтоолгохоор тооцоо судалгааг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01-1/07 дугаар бичгээр ирүүлсний дагуу тарифыг “Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 187 дугаар тушаалын 14 дүгээр хавсралтаар баталсан “Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журам”-ын дагуу хянан үзэж, 1 дүгээр сард зөвлөмжийг ЗТХЯ-нд хүргүүлсэн.

“Ховд” нисэх буудлын зорчигч үйлчилгээний хураамжийг “Иргэний нисэхийн төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээ, үйлчилгээний орлогыг зарцуулах журам”-ын дагуу хянаж, холбогдох зөвлөмжид нийцүүлэн мөрдөн ажиллахыг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн албан тоотор Иргэний нисэхийн үндэсний төвд мэдэгдсэн.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 09/2420 дугаар албан бичгийн дагуу Улаанбаатар-Токио-Улаанбаатар чиглэлийн нислэгийн тийзийн үнийн судалгаа хийн 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 01/1185 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.



Иргэний нисэхийн ерөнхий газрын орлогын үзүүлэлт, өнгөрөлтийн нислэг, дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгчдийн навигацийн үйлчилгээний хураамжид төлж буй дүнгийн талаар холбогдох судалгааг 2022 оны 5 дугаар сард боловсруулж, удирдлагад танилцуулсан.

Зам, тээврийн хөгжлийн яамны 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 09/1735 дугаар албан бичгийн дагуу дотоодын агаарын тээвэрлэгчдээс агаарын тээврийн үйлчилгээг сэргээхэд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, тийзийн үнэ, ачаа тээврийн тарифыг бууруулах, суудал ашиглалтыг нэмэгдүүлэх боломжийн талаар саналыг албан бичгээр авч, агаарын тээврийн салбарын үйл ажиллагааг сэргээх, /Ковид-19/ цар тахлын нөлөөллийг бууруулахтай холбоотойгоор олон улсад зөвлөмж болгосон болон авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар судлан манай улсын хувьд тулгамдаж буй асуудал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, дотоодын агаарын тээвэрлэгчдийн саналын хамт нэгтгэн, удирдлагад танилцуулж, 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/827 дугаар албан бичгээр Зам тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Агаарын хөлгийн шатахууны үнийн өсөлттэй холбоотой 2022 оны эхний хагас жилийн агаарын хөлгийн шатахууны импорт, үнэ, нийлүүлэлтийн судалгаа хийж 2022 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Зам тээврийн хөгжлийн яаманд цахимаар хүргүүлсэн.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 108 дугаар захирамжаар байгуулагдсан Бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг судалж, цаашид шаардлагатай арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий дэд ажлын хэсгийг Зам, тээврийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/225 дугаар тушаалаар байгуулагдсантай холбогдуулан 2022 оны 8 сарын 19-ний өдөр ЗТХЯ-ны хурлын зааланд зохион байгуулсан ажлын хэсгийн хуралд оролцож, хуваарьт нислэг гүйцэтгэж буй дотоодын агаарын тээвэрлэгчдээс тийзийн үнийн мэдээлэл авч танилцуулга боловсруулан ЗТХЯ-нд 2022 оны 8 дугаар сарын 22-ны өдөр цахимаар хүргүүлсэн.

Зам тээврийн хөгжлийн яамны 2022 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 09/2420 дугаар албан бичгийн дагуу JAL, ANA агаарын тээвэрлэгч компаниудын нислэгийн тийзийн үнэ болон БНХАУ, Филиппин, Тайланд, Тайван, гэх зэрэг улс орнууд руу зорчиж буй япон жуулчдын тооны судалгаа болон Улаанбаатар-Токио-Улаанбаатар чиглэлийн нислэгийн тийзийн үнийн судалгаа хийн 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 01/1185 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.

#### ***Агаарын тээвэрлэгчидтэй холбогдох чиглэлээрх гадаад хамтын ажиллагаа:***

Бүгд Найрамдах Казахстан Улсын /Ковид-19/ цар тахлын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх салбар хоорондын комиссын шийдвэрийн дагуу Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Монгол Улсын хоорондын нислэгийг буцаан сэргээж 7 хоногт нийт 4 удаагийн давтамжтай нислэг үйлдэхийг зөвшөөрсөн бөгөөд Нур-Султан-Улаанбаатар чиглэлд 2 удаагийн давтамж, Алматы- Улаанбаатар чиглэлд 2 давтамжтайгаар нислэг үйлдэхийг зөвшөөрөх шийдвэр гарсан талаар тус улсын Аж үйлдвэр, дэд бүтцийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн хорооноос 2022 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 28-28/230 дугаар бичгээр мэдэгдсэн бөгөөд Монгол Улсын агаарын тээвэрлэгчийн зүгээс холбогдох нислэгийн хүсэлтүүдээ Бүгд Найрамдах Казахстан Улсын Иргэний нисэхийн хороонд гаргахыг хүссэнийг Хүннү Эйр ХХК-д 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдөр хүргүүлсэн.

“МИАТ” ХК-иас тус газарт 2022 оны 3 дугаар сарын 14-ны өдөр ирүүлсэн 01/414 дүгээр албан бичигт Улаанбаатар-Франкфурт-Улаанбаатар чиглэлийн нислэгийн алдагдлыг бууруулах, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Москва-Улаанбаатар-Москва чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрх эдлэн Франкфуртын чиглэлд нислэг үйлдэх хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан Москва-Улаанбаатар-Москва чиглэлд агаарын тээврийн 5 дугаар эрх тохирох асуудлыг ОХУ-ын талтай ажлын шугамаар тохиролцох арга хэмжээ авах хүсэлтийг ЗТХЯ-нд 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

Оросын Холбооны Улсын Тээврийн яам болон Холбооны агаарын тээврийн агентлагаас ОХУ, Монгол Улс болон гуравдагч орны иргэдийг тээвэрлэх ложистикийн сүлжээг бий болгох асуудлыг хэлэлцэхээр ОХУ, Монголын агаарын тээврийн компаниудын мэргэжилтнүүдийг оролцуулан ажлын уулзалтыг ойрын хугацаанд зохион байгуулах, Гадаадын даатгалын компаниуд ОХУ-д хийх нислэгт даатгалын үйлчилгээг хүчингүй болгож байгаа тул Монголын агаарын тээврийн “МИАТ ТӨХК”-ийн агаарын хөлгүүдийг ОХУ-ын даатгалд хамруулах боломжтой ОХУ-ын даатгалын компаниудын холбоо барих мэдээллийг ирүүлсэнтэй холбогдуулан дээрх арга хэмжээнд оролцох



талаар Зам, тээврийн хөгжлийн яамнаас холбогдох чиглэл авах албан бичгийг 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдөр хүргүүлсэн.

“Ашиана Эйрлайнс” компанийн Тэргүүн дэд захирал КИМ ТАЕYUP тэргүүтэй төлөөлөгчид ИНЕГ-ын дарга С.Мөнхнасангай 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хийсэн уулзалтыг зохион байгуулсан.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсад коронавируст /Ковид-19/ халдварын тархалт нэмэгдэж гадаад улсаас зөөвөрлөгдсөн тохиолдол ихээр гарч байгаатай холбогдуулан Монгол Улсаас гадаад улсаар дамжин Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу зорчих зорчигчдоос антиген илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ нэмэлтээр шаардах болсон тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамнаас 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн ноот бичгээр мэдэгдсэнтэй холбогдуулан Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу зорчих зорчигчид тавигдаж буй шаардлагын талаарх мэдээллийг агаарын тээвэрлэгчдэд 2022 оны 4 дүгээр сарын 07/545 дугаар албан бичгээр хүргүүлэн холбогдох арга хэмжээ авч зорчигчдыг мэдээллээр хангаж ажиллахыг мэдэгдсэн.

Оросын Холбооны Улсын холбооны агаарын тээврийн агентлаг (ФАВТ) 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 10200/09 дүгээр албан бичгээр ОХУ, Монгол Улс болон гуравдагч орны иргэдийг тээвэрлэх ложистикийн сүлжээг бий болгох асуудлыг хэлэлцэхээр ОХУ, Монгол Улсын агаарын тээврийн компаниудыг оролцуулан ажлын уулзалт зохион байгуулах хүсэлтийг ирүүлсэн мөн ОХУ-ын Холбооны агаарын тээврийн агентлаг нь 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 10201/09 дүгээр албан бичгээр гадаадын даатгалын компаниуд ОХУ-д үйлдэх нислэгийг даатгахаас татгалзаж байгаа тул “МИАТ ТӨХК” компанийн агаарын хөлгүүдийг даатгалд хамруулах талаар ярилцах хүсэлтэй байгааг илэрхийлэн “Альфа Даатгал”, “Оросын Үндэсний давхар даатгалын компани”-тай холбоо барих мэдээллийг ирүүлснийг “МИАТ” ТӨХК-д хүргүүлэн ОХУ-ын Холбооны агаарын тээврийн агентлагтай хийх уулзалтад оролцохтой холбоотой бэлтгэлийг хангаж, уулзалтын үеэр хэлэлцэх асуудлын талаарх саналаа ирүүлэхийг 2022 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 07/595 дугаар албан бичгээр “МИАТ” ТӨХК-д мэдэгдсэн.

“Изинис Эйрвэйз” ХХК-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонг Конгийн Агаарын харилцааны тухай хэлэлцээрт өөрчлөлт оруулах, Хонг Конгоос Мехико, Сао Паоло, Бангкок, Шинэ Дели, Сидней, Манила, Коломбо хотууд руу ачаа тээврийн 5 дугаар эрхийн зохицуулалт тохирох талаар судалж байна. Үүний дагуу Мехикогийн талтай цахимаар харилцаж ирүүлсэн хариуг тус газрын даргад танилцуулсан.

“МИАТ” ТӨХК-ийн зүгээс дан ачаа тээврийн нислэгийг хөгжүүлэх зорилгоор В757-2F маягийн агаарын хөлөг авах бэлтгэл ажлыг хангаж байгааг албан тоотоор ирүүлсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын гаднын улс орнуудтай байгуулсан Агаарын харилцааны тухай хэлэлцээрт ачаа тээвэрлэлттэй холбоотой нэмэлт өөрчлөлт оруулах, зарим улстай шинээр Агаарын харилцааны тухай хэлэлцээр байгуулах болон холбогдох чиглэлүүдэд ачаа тээврийн нислэг үйлдэхээр агаарын тээвэрлэгчийн томилгоо авах хүсэлтийг судлан, Иргэний нисэхийн ерөнхий газрын саналыг боловсруулан ЗТХЯ-нд 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 01/986 дугаар албан бичгээр хүргүүлсэн.

“Хүннү Эйр” ХХК-ийн Улаан-Үд хотноо 2022 оны 5 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Орос-Монгол бодит байдал, шинэ түншлэл” дээд хэмжээний форумд оролцох төлөөлөгчдийг тээвэрлэхээр 2022 оны 5 дугаар сарын 26, 28-ны өдрүүдэд Улаанбаатар-Улаан-Үд-Улаанбаатар чиглэлд ОХУ-ын даатгалын компанид давхар даатгагдсан АTR-72 маягийн агаарын хөлгөөр нислэг үйлдэх болон тус чиглэлийн хуваарьт нислэгийг 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эргэн сэргээн долоо хоногт 2 удаагийн нислэгийг Мягмар, Бямба гарагуудад үйлдэхээр холбогдох бэлтгэл ажлыг хангаж байгаа талаарх мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яаманд 2022 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 01/941 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанаас 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн албан бичгээр Хятад, Монгол хоёр орны хооронд зорчигч тээврийн хуваарьт нислэгийг сэргээж байгаа талаар тал бүр хоёр долоо хоног тутамд нэг нислэг үйлдэх талаар мэдэгдэж, Монголын талаас нислэг үйлдэх компаниуд болон чиглэлүүдийн талаарх мэдээлэл ирүүлэхийг хүссэнтэй холбогдуулан 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “МИАТ” ТӨХК нь Улаанбаатар-Гуанжоу-Улаанбаатар чиглэлд, “Аэромонголиа” ХХК нь Улаанбаатар-Хөх Хот-Улаанбаатар чиглэлд хоёр долоо хоногт тус бүр нэг удаагийн хуваарьт нислэг үйлдүүлэх саналыг Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий



газрын зүгээс 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 01/27 дугаар албан бичгээр БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанд хүргүүлсэн.

Бүгд Найрамдах Буриад Улсын Улаан-Үд хотод 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн Монгол Улс, ОХУ-ын хооронд агаарын тээврийг сэргээх, Орос, Монгол болон гуравдагч орны иргэдийг тээвэрлэх логистикийн сүлжээг бий болгох зорилгоор албан уулзалтын талаарх тайлан болон протоколыг хавсарган 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 01/1204 дүгээр албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 1989 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр байгуулсан Иргэний агаарын тээврийн тухай хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн дагуу “МИАТ” ТӨХК нь Улаанбаатар – Бээжин – Улаанбаатар, Улаанбаатар – Тяньжин – Улаанбаатар, Улаанбаатар – Шанхай – Улаанбаатар, Улаанбаатар – Гуанжоу – Улаанбаатар, Улаанбаатар – Хөх хот – Улаанбаатар, Улаанбаатар – Чендү – Улаанбаатар, Улаанбаатар – Эрээн – Улаанбаатар чиглэлүүдэд ачаа тээврийн үйлчилгээ үзүүлэх агаарын тээвэрлэгчээр томилогдсон талаар 2022 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/55 дугаар албан бичгийг БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанд хүргүүлсэн.

“МИАТ” ТӨХК Улаанбаатар – Бээжин – Улаанбаатар, Улаанбаатар – Тяньжин – Улаанбаатар, Улаанбаатар – Шанхай – Улаанбаатар, Улаанбаатар – Гуанжоу – Улаанбаатар, Улаанбаатар – Хөх хот – Улаанбаатар, Улаанбаатар – Чендү – Улаанбаатар чиглэлүүдэд карго нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилогдсонтой холбогдуулан нислэгийн зөвшөөрөл олгох тухай хүсэлтийг БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанд 2022 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 01/72 дугаар албан бичиг хүргүүлсэн.

“МИАТ” ТӨХК БНХАУ-ын орон нутгийн засаг захиргаанаас Хөх хотоор дамжин Бээжин хот руу нислэг үйлдэх зөвшөөрөл авсантай холбогдуулан хоёр улсын нийслэл хот хоорондох энэхүү чухал нислэгийг сэргээх зорилгоор “МИАТ” ТӨХК-нд Улаанбаатар-Хөх хот-Бээжин-Улаанбаатар чиглэлд нислэг үйлдэх зөвшөөрөл олгох хүсэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 01/74 дүгээр албан бичгээр БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанд хүргүүлсэн.

ОХУ-ын Холбооны Агаарын тээврийн агентлагаас 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн ИСХ-25437/09 дүгээр албан бичгээр ОХУ-ын агаарын тээврийн компаниудын агаарын хөлгийг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх нисэх онгоцны буудлуудад саатуулахгүй, баривчлахгүй байх баталгааг Монгол Улсын Иргэний нисэхийн байгууллага өгч чадах эсэх талаар Монгол Улсын зүгээс байр сууриа илэрхийлэхийг хүссэн албан бичгийг тус газарт дахин ирүүлсэн. Иймд дээрх асуудлаар тухайлан баримтлах чиглэл өгөхийг 2022 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 01/1276 дугаар албан бичгээр ГХЯ-нд хүргүүлсэн.

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хооронд олон улсын нислэгийн тоо, Улаанбаатар-Гуанжоу чиглэлийн нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх, мөн Бээжин чиглэлийн нислэгийг сэргээх хүсэлтээ 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 01/48 дугаар албан бичгээр БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанд хүргүүлсэн.

БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яаманд Иргэний нисэхийн ерөнхий газрын зүгээс “МИАТ” ТӨХК-ийн ОМ 309/ОМ 310 дугаартай хуваарьт нислэгт Korea Airport Service Co.,Ltd. газрын үйлчилгээ үзүүлэх боломж олгож өгөхийг хүсэж 7 дугаар сарын 08-ны өдөр 01/45 дугаар албан бичгийг хүргүүлсэн.

“Аэромонголиа” ХХК Улаанбаатар-Сөүл чиглэлд тус компани долоо хоногт 3 удаагийн нислэг үйлдэхээр томилогдсон бөгөөд холбогдох нислэг үйлдэх зөвшөөрөл олгож өгөхийг хүссэн хүсэлтийг 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 01/60 дугаар албан бичгээр БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яаманд хүргүүлсэн.

“МИАТ” ТӨХК Тайландын Вант Улсын Пукет хот руу нислэг үйлдэхээр томилогдох хүсэлт ирүүлсэнтэй холбогдуулан тус чиглэлд долоо хоногийн 500 суудлын багтаамжтай нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээр томилохыг дэмжсэн ИНЕГ-ын саналыг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 01/1443 дугаар албан бичгээр хүргүүлсэн.



Монгол Улс, БНХАУ тус бүр долоо хоногийн 3 удаагийн нислэгийн давтамж буюу хоёр улс хооронд нийт 6 удаагийн нислэг үйлдэх бэлтгэл ажлыг талууд хангаж байгаа тухай 2022 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 01/1523 дугаар албан бичгийг ГХЯ-нд хүргүүлсэн.

“МИАТ” ТӨХК нь Улаанбаатар-Бангкок-Пукет-Бангкок-Улаанбаатар чиглэлд зорчигч үйлчилгээ үзүүлэх хүсэлтээ Тайландын Хаант Улсын Иргэний нисэхийн удирдах байгууллагад хүргүүлсний дагуу Бангкок-Пукет-Бангкок чиглэлд Агаарын тээврийн 7 дугаар эрхийг эдлэхгүйгээр нислэг үйлдэх хүсэлтэй байгаа тухай 2022 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 01/69 дүгээр албан бичгээр Тайландын талд хүргүүлсэн.

Шинээр байгуулагдсан Монголын агаарын тээврийн компани “Зорт Эйр” ХХК-д Олон улсын нислэг гүйцэтгэхэд ОУИНБ-ын шаардлагын дагуу 3 үсгийн код авах шаардлагатай бөгөөд ZAA эсвэл ZRT код гаргаж өгөхийг хүссэн албан тоотыг бэлтгэж 2022 оны 9 дүгээр сарын 06-ны өдрийн 01/68 дугаар албан бичгээр Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Агаарын навигацийн албаны дарга Stephen P. Creamer-т хүргүүлсэн.

Улаанбаатар-Бээжин чиглэлийн нислэгийг сэргээх хүсэлтийг БНХАУ-ын талд уламжилж өгөх хүсэлтийг ГХЯ-нд 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

Хүннү Эйр ХХК Бүгд Найрамдах Энэтхэг Улсын чиглэлд захиалгат нислэг үйлдэхээр төлөвлөж байгаатай холбогдуулан захиалгат нислэгийн зорчигчдоос өөр зорчигчид тухайн нислэгт авах тухай хүсэлтийг БНЭУ-ын ИНЕГ-т 9 сарын 27-ны өдөр хүргүүлсэн.

Т’Вэй Эйр, Жэжү Эйр, Инчеоны агаарын тээвэрлэгч компаниудад Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хооронд 1991 оны 10 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан хэлэлцээрийн дагуу хоёр улсын хооронд нислэг үйлдэхээр томилогдсон агаарын тээвэрлэгчид нислэг үйлдэж буй чиглэлдээ мөрдөж буй тарифыг Иргэний нисэхийн ерөнхий газарт тогтмол мэдэгдэх шаардлагатайг мэдэгдсэн.

БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргаанаас Иргэний агаарын тээврийн тухай Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 1989 оны 4 дүгээр сарын 18-ний өдөр байгуулсан хэлэлцээрийн тарифын заалтад өөрчлөлт оруулах тухай саналыг 2022 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр ирүүлсэнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 07/1715 дугаар албан бичгээр Монгол Улсын Агаарын тээвэрлэгчид болох “МИАТ” ТӨХК, “Изинис Эйрвэйс” ХХК, “Хүннү Эйр” ХХК, “Аэромонголиа” ХХК, “Монголиан Эйрвэйс Карго” ХХК-д хүргүүлсэн.

Улаанбаатар-Харбин-Улаанбаатар чиглэлд нислэг гүйцэтгэж байсан “Хүннү Эйр” агаарын тээвэрлэгч компани Харбин чиглэлийн хуваарьт нислэгийг сэргээж, нислэг үйлдэх хүсэлтээ ирүүлсний дагуу Улаанбаатар-Харбин-Улаанбаатар чиглэлд нислэгийн давтамжийг нэмэх асуудал дээр холбогдуулах арга хэмжээ авч өгөх тухай 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 01/83 дугаар албан бичгээр БНХАУ-ын Иргэний нисэхийн захиргааны олон улсын харилцааны дэд дарга Чэн Вэйд хүргүүлсэн.

### **ГУРАВ. НИСЭХИЙН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ БОЛОН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 8.5, ИНЕГ-ын даргын “Эрх, үүрэг шилжүүлэх тухай гэрээ”-ний хүрээнд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын алба /НААХЗА/ нь Монгол улсын иргэний нисэхийн салбарын зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, иргэний нисэхийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх замаар иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангуулах үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаагаа явуулж байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 70 дугаартай тушаал болон Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны А/728 дугаартай тушаалаар Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт зохицуулалтын алба нь Нислэгийн стандарт үйл ажиллагааны хяналтын хэлтэс, Нислэгт тэнцэх чадварын хэлтэс, Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс, Үнэмлэх гэрчилгээжүүлэлтийн хэлтэс гэсэн 4 хэлтэстэй үйл ажиллагаа явуулж байна.

### **НИСЛЭГИЙН СТАНДАРТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТЫН ХЭЛТЭС**



Нислэгийн стандарт, үйл ажиллагааны хяналтын хэлтэс нь Чикагогийн конвенц, түүний хавсралт дахь стандарт зөвлөмжүүд, Иргэний нисэхийн тухай Монгол улсын хууль, ИНБД, ИНЕГ-ын даргын тушаал, журам болон хэлтсийн үйл ажиллагааны заавар, журмуудын хүрээнд үндэсний агаарын тээвэрлэгчид болон Монгол Улс руу арилжааны тогтмол нислэг үйлдэж буй гадаадын агаарын тээвэрлэгчийн үйл ажиллагаа, чөлөөт нисэхийн үйл ажиллагаа, хөдөө аж ахуйн зориулалттай агаарын хөлгийн үйл ажиллагаа, нисэх клуб болон нисэхийн сургалтын байгууллагыг гэрчилгээжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих замаар нисэхийн аюулгүй ажиллагааг хангуулахад чиглэсэн мэргэжлийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Мөн хувийн нисэхийн үйл ажиллагаа болон зорчигчгүй агаарын хөлөг, хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй.

| № | Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгож буй үйл ажиллагаа                         | Зөвшөөрөл олгож буй этгээд |          | ИНД     | Дүрмийн нэр  |
|---|---|----------------------------|----------|---------|--|
|   |   | Аж ахуйн нэгж              | Хувь хүн |         |  |
| 1 | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ   | ✓                          |          | ИНД-119 | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт                           |
| 2 | Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ                                    | ✓                          |          | ИНД-129 | Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээжүүлэлт                  |
| 3 | Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын гэрчилгээ         | ✓                          | ✓        | ИНД-102 | Хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт |
| 4 | Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын гэрчилгээ                | ✓                          | ✓        | ИНД-115 | Чөлөөт нисэхийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээжүүлэлт        |
| 5 | Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын гэрчилгээ | ✓                          |          | ИНД-137 | Хөдөө аж ахуйн агаарын хөлгийн үйл ажиллагаа                     |
| 6 | Нисэх клубийн гэрчилгээ   | ✓                          |          | ИНД-149 | Нисэх клубийн гэрчилгээжүүлэлт                                   |

### **АЭРОДРОМ, АГААРЫН НАВИГАЦИЙН ХЯНАЛТЫН ХЭЛТЭС**

Аэродром, агаарын навигацийн хяналтын хэлтэс нь ИНЕГ-ын даргаас шилжигдсэн эрхийн хүрээнд Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, агаарын навигацийн техникийн үйлчилгээ, нислэгийн журмын үйлчилгээ, нисэхийн мэдээллийн үйлчилгээ, нисэхийн цаг уурын үйлчилгээ, нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээ, зохицуулалттай агаарын ачааны байгууллага, аэродромын үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудыг иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжүүлэх, гэрчилгээг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, холбогдох стандарт, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулж, үйл ажиллагааны журам, заавар, технологийн баримт бичгүүдийг хянах, баталгаажуулах ажлыг хариуцна.

| № | Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгож буй үйл ажиллагаа          | Зөвшөөрөл олгож буй этгээд |          | Иргэний нисэхийн дүрэм | Дүрмийн нэр   |
|---|--|----------------------------|----------|------------------------|---|
|   |  | Аж ахуйн нэгж              | Хувь хүн |                        |   |
| 1 | Аэродромын гэрчилгээ   | ✓                          |          | ИНД-139                | Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт                                |
| 2 | Хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ                          | ✓                          |          | ИНД-139                | Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт                                |
| 3 | Нисэхийн аюулгүй байдлын үйлчилгээний байгууллагын гэрчилгээ | ✓                          |          | ИНД-140                | Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт |
| 4 | Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллага           | ✓                          |          | ИНД-171                | Агаарын навигацийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт      |
| 5 | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага               | ✓                          |          | ИНД-172                | Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт          |





|   |   |   |  |         |   |
|---|---|---|--|---------|---|
| 6 | Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллага | ✓ |  | ИНД-173 | Хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт |
| 7 | Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллага           | ✓ |  | ИНД-174 | Нисэхийн цаг уурын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт           |
| 8 | Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллага          | ✓ |  | ИНД-175 | Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт          |

### НИСЛЭГТ ТЭНЦЭХ ЧАДВАРЫН ХЭЛТЭС

Нислэгт тэнцэх чадварын хэлтэс нь ИНЕГ-ын бүтцийн нэгжийн хувьд Иргэний нисэхийн зориулалтаар нислэг үйлдэх Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгүүдийн нислэгт тэнцэх чадварт хяналт тавих, агаарын хөлгийн Техник үйлчилгээний байгууллага, Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах байгууллагын үйл ажиллагаа болон агаарын тээвэрлэгч компаниудын агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын хадгалалт нь олон улсын болон Монгол улсын иргэний нисэхийн хууль, дүрэм, стандарт шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг.

| №  | Тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгож буй үйл ажиллагаа                           | Зөвшөөрөл олгож буй этгээд |          | ИНД     | Дүрмийн нэр   |
|----|---|----------------------------|----------|---------|---|
|    |   | Аж ахуйн нэгж              | Хувь хүн |         |   |
| 1  | Агаарын хөлгийн бүртгэл   | ✓                          | ✓        | ИНД-47  | Агаарын хөлгийн бүртгэл   |
| 2  | Агаарын хөлгийг бүртгэлээс хасах гэрчилгээ                                    | ✓                          | ✓        |         |   |
| 3  | Агаарын хөлгийн Нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ                             | ✓                          | ✓        | ИНД-21  | Бүтээгдэхүүн, эд ангийн гэрчилгээжүүлэлт                          |
| 4  | Агаарын хөлгийн маягийн гэрчилгээ   | ✓                          |          |         |   |
| 5  | Экспортын гэрчилгээ   | ✓                          | ✓        |         |   |
| 6  | Тусгай нислэгийн гэрчилгээ  | ✓                          | ✓        |         |   |
| 7  | Дуу чимээний гэрчилгээ  | ✓                          | ✓        |         |   |
| 8  | Радио холбооны зөвшөөрөл  | ✓                          | ✓        |         |   |
| 9  | Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээ                    | ✓                          |          | ИНД-145 | Агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт |
| 10 | Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах байгууллагын гэрчилгээжүүлэлт | ✓                          |          | ИНД-144 | Хангамжийн байгууллагын гэрчилгээжүүлэлт                          |

### ҮНЭМЛЭХ, ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТИЙН ХЭЛТЭС

Үнэмлэх, гэрчилгээжүүлэлтийн хэлтэс нь 2022 онд байгууллагуудад 14 үзлэг шалгалтыг төлөвлөсөн байгаагаас 10 үзлэг шалгалтыг гүйцэтгэсэн ба 4 үзлэг шалгалтыг гүйцэтгэж байна.

| № | Байгууллага                   | Үзлэг шалгалт                           | Гүйцэтгэсэн огноо |
|---|-------------------------------|---|-------------------|
| 1 | “Изинис Эйрвэйз” ХХК          | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.01.10-14     |
| 2 | “Монголиан Эйрвэйз Карго” ХХК | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.01.17-26     |
| 3 | “Хүннү Эйр” ХХК               | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.03.02-14     |
| 4 | “Аэромонголиа” ХХК            | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.04.06-27     |
| 5 | “Геосан” ХХК                  | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.06.06-15     |
| 6 | “Тэнгэрийн улаач-Шинэ” ХХК    | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.06.06-15     |
| 7 | “Монголиан Эйрвэйс” ХХК       | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.06.06-15     |
| 8 | “Монголын нисэхийн академи”   | Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ сунгах  | 2022.05.30-06.10  |
| 9 | “Ханseo” их сургууль          | Сургалтын байгууллагын гэрчилгээ сунгах | 2022.05.11-07.06  |



- ИНД-61-ийн дагуу төлөвлөсөн ажил:115
  - Нисгэгчийн үнэмлэх эзэмшигч нийт-164
  - Агаарын нисгэгчийн үнэмлэх эзэмшигч-68
  - Коммерийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч-92
  - Хувийн нисгэгчийн үнэмлэх эзэмшигч-4
  - Гадаадын нисгэгчийн үнэмлэх хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ эзэмшигч-10
  - Зэрэглэлийн хүчинтэй хугацаа сунгасан-137
  - Шинээр маягийн зэрэглэл олгосон, сунгасан-16
  - Шинээр коммерийн нисгэгчийн үнэмлэх олгосон-3
  - Шинээр хувийн нисгэгчийн үнэмлэх олгосон-3
  - Багшийн зэрэглэл-3
  - ASPEQ шалгалт-162 –давхардсан тоогоор/
  - Гадаадын нисгэгчийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн гэрчилгээ-16
- ИНД-65-ийн дагуу төлөвлөсөн ажил:180
  - НХҮА-ны үнэмлэх эзэмшигч нийт-232
  - Нислэгийн удирдагчийн үнэмлэх эзэмшигч-172
  - Нислэгийн мэдээллийн ажилтны үнэмлэх эзэмшигч-60
  - Зэрэглэлийн хүчинтэй хугацаа сунгасан-194
  - Шинээр маягийн зэрэглэл олгосон болон шинэчилсэн-16
  - Шинээр үнэмлэх олгосон-8
  - Багшийн зэрэглэл сунгасан-7
  - Шалгагчийн зэрэглэл-3
- ИНД-66-ийн дагуу төлөвлөсөн ажил:85
  - Агаарын хөлгийн *техник үйлчилгээний ажилтны үнэмлэх эзэмшигч-130*
  - Маягийн зэрэглэл шинээр олгосон-16
  - Зэрэглэлийн хүчинтэй хугацаа баталгаажуулсан-89
  - Маягийн зэрэглэл шинээр олгосон-16
  - Шинээр үнэмлэх олгосон-6
  - Үнэмлэх шинэчилсэн-3
  - ТҮБГ /МАС/-40
  - Нэмэлт категори-3
  - Гадаадын инженерийн үнэмлэхийг хүлээн зөвшөөрсөн-5
  - ASPEQ шалгалт-31
- ИНД-67-ийн дагуу төлөвлөсөн ажил:203
  - Эрүүл мэндийн гэрчилгээ эзэмшигч нийт-341
  - Эрүүл мэндийн I ангиллын гэрчилгээг -136
  - Эрүүл мэндийн II ангиллын гэрчилгээг -0
  - Эрүүл мэндийн III ангиллын гэрчилгээг – 120
  - Сэтгэл зүйн шалгалт
  - Эрүүл мэндийн I ангиллын гэрчилгээ эзэмшигч шинээр- 12
  - Хугацааны давтамжаар-32
  - Эрүүл мэндийн II ангиллын гэрчилгээ эзэмшигч-0
  - Эрүүл мэндийн III ангиллын гэрчилгээ эзэмшигч шинээр-4
  - Хугацааны давтамжаар-28
- ICAO-ийн хэлний ур чадварын шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих: ICAO-ийн хэлний ур чадварын TEAP шалгалтад хамрагдсан нислэгийн удирдагч, нисгэгч нарын TEAP шалгалтын баримт бичгүүдийг хүлээн авч, Annex 1/1.2.9/, ИНД-61.11/61.11(b); ИНД-65/65.13(2), 65.27(a)/-д заасан хэлний ур чадварын шаардлагын нийцлийг шалгаж тус шалгалтад тэнцсэн 127 нисгэгч, нислэгийн удирдагчийн хэлний ур чадварын 4, 5 болон 6-р түвшнийг баталгаажуулж байцаагчийн дүгнэлт гаргасан.
- ИНД-141, 147-дүрмүүдийн гэрчилгээжүүлэлтийн хүрээнд: 5



- “Ханseo” их сургуулийг ИНД-141.11-ийн дагуу дахин гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрүүдэд гүйцэтгэж сургалтын байгууллагын гэрчилгээг 2027 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл таван жилээр олгосон.
- TFT-THAI FLIGHT TRAINING сургалтын төвд ИНД-141-ийн дагуу үзлэг шалгалт хийж МСAA.141.25 дугаартай нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг 2023 оны 08 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл нэг жилээр олгосон.
- “Кореан Эйр” компанийн “Cabin Crew Training Center” сургалтын байгууллагад ИНД-141.11-ийн дагуу дахин гэрчилгээжүүлэх үзлэг шалгалтыг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 19-ний өдрүүдэд гүйцэтгэж сургалтын байгууллагын гэрчилгээг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл нэг жилээр олгосон.
- Франц улсын “SIMAERO” сургалтын байгууллагад ИНД-141-ийн дагуу үзлэг шалгалт хийж МСAA.141.36 дугаартай нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл нэг жилээр олгосон.
- Чех улсын “CZECH AVIATION TRAINING CENTRE” сургалтын байгууллагад ИНД-141-ийн дагуу үзлэг шалгалт хийж МСAA.147.01 дугаартай нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээг 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл гурван жилээр олгосон.

### **ДӨРӨВ. БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

#### ***Агаарын навигацгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах:***

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/10 дугаар "Агаарын зам шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалын төслийг боловсруулахтай холбоотойгоор тушаалын хэрэгжилтэд санал боловсруулах ажлын багийг 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр томилсон бөгөөд ажлын төлөвлөгөөг 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдөр батлуулж, төлөвлөгөөний дагуу ажиллаж төслийн боловсруулалтыг хийж, хэлэлцүүлэг болон аюулгүй ажиллагааны үнэлгээнүүдийг нэгтгэн боловсруулж Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр санал төслийг хүргүүлсэн. Тушаалын төсөлд Монгол Улсын агаарын зайн дээд агаарын замууд G218, A310, B208, B330-ыг үзүүлэлтэд тулгуурласан навигац бүхий агаарын замууд болох Y327, Y520, Y746, Y962-тэй нэгтгэсэн бөгөөд шинээр 6 үзүүлэлтэд тулгуурласан агаарын замуудыг тогтоосон, 88 цэгийн таван үсгийн нэршлийн кодыг шинээр үүсгэн ICARD системд бүртгүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын Агаарын замын тушаалын төсөлд дараах нэмэлт хавсралтуудыг боловсруулсан. Үүнд:

- Үндсэн цэгүүд /заавал илтгэх цэгүүд, хүсэлтээр илтгэх цэгүүд/
- Нислэгийн хөдөлгөөний удирдлагын сектор зохион байгуулалт /Мөрөн, Төв, Дорнод, Алтай, Баян, Говь/

Агаарын навигацгийн үйлчилгээний тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгаанд үндэслэн агаарын зам, сектор зохион байгуулалт мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/210 дугаар "Агаарын зам тогтоож, нэмэлт өөрчлөлт оруулах" тушаалын дагуу ИНЕГ-ын даргын Агаарын замын тушаалын төсөлд нэмэлтээр G401 агаарын замын мэдээллийг оруулж саналыг боловсруулж Иргэний нисэхийн ерөнхий газрын Агаарын навигац, нисэх буудлын бодлого зохицуулалтын газарт 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдөр цахим хаягаар хүргүүлсэн бөгөөд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/208 дугаар тушаалаар батлагдсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/210 дугаар тушаалын дагуу G401 агаарын замын мэдээллийг 10 дугаар сарын 06-ны өдрийн НМЭ-ээр хүчин төгөлдөр болох хүртэл NOTAM мэдээгээр зарлуулсан.

Үзүүлэлтэд тулгуурласан навигац (PBN)-ийн 6 агаарын зам, нислэгийн журмуудыг шинэчлэн тогтоох төлөвлөгөөний төслийг Агаарын навигац, нисэх буудлын бодлого зохицуулалтын газарт цахим хаягаар 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хүргүүлсэн.

Агаарын замын өөрчлөлттэй холбоотойгоор “Чингис хаан” ОУНБ, “Буянт-Ухаа” ОУНБ, “Алтай”, “Дэглий цагаан”, “Мөрөн”, “Чойбалсан”, Даланзадгад” нисэх буудлуудын хэрэглэлийн нислэгийн журмуудад өөрчлөлт оруулан НААХЗА-аар хянуулж батлуулан НМЭ (AIP AIRAC AMDT 09/22)- ээр зарлан мэдээлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/10 дугаар "Агаарын зам шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Олон Улсын цагаар 00.00 UTC /орон нутгийн цагаар 08.00/ цагаас эхлэн Монгол улсын агаарын замын шинэчлэлийг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд албан ёсоор ашиглаж эхлэхтэй холбоотойгоор “EASY BUSY 2030” буюу “Хил хязгааргүй нисэх-2030” нээлтийн үйл ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан. Арга хэмжээнд ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Иргэний



нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Мөнхтуяа, ИНЕГ-ын дарга С.Мөнхнасан, ИНУТ-ийн даргын үүргийг хавсран гүйцэтгэгч Н.Батсайхан болон ИНЕГ, ИНУТ-ийн газрын дарга нар, АНУГ-ын албаны дарга нар, агаарын тээвэрлэгчид мөн хэвлэл мэдээллийн байгууллагууд хүрэлцэн ирж оролцсон. Арга хэмжээний нээлтийн үеэр ИНЕГ-ын үүсэл хөгжил болон өнөөг хүртэл хийгдсэн томоохон ажлууд, мөн Монгол улсын агаарын зам, агаарын зохион байгуулалтыг түүхчлэн харуулсан видео танилцуулгыг бэлтгэн ирсэн зочид төлөөлөгчдөд танилцуулсан. Мөн тус арга хэмжээний үеэр АНУГ-ын албад (НХҮА, НМҮА, НУТА, ХНАА, НЖБШНА, ГСЦХА) тус бүр албаны үйл ажиллагаагаа сурталчилан таниулах зорилгоор булан бэлтгэж оролцсон. Агаарын зайн шинэчлэлттэй холбоотой ажилд хувь нэмрээ оруулсан ажилтнуудыг үнэлж ИНЕГ-аас баярын “БАТЛАМЖ” бичгийг гардуулан өгсөн.

Агаарын навигацийн үйлчилгээнд ажиглалтын тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх зорилгоор 2007 оноос эхлэн хэрэгжүүлсэн төслийн үр дүнд 2012 оны 08 дугаар сарын 23-ны өдөр нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээнд ажиглалтын тоног төхөөрөмжийг амжилттай нэвтрүүлсэн. Автомат хамааралтай ажиглалтын систем (ADS-B)-ийн газрын станцын хамрах хүрээг сайжруулах ажлын хүрээнд:

2012 оноос хойш өнөөг хүртэл 7 иж бүрдэл ажиглалтын радиолокаторийн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар 4 ажиглалтын удирдлагын бүсэд ажиглалтын удирдлагын үйлчилгээ явуулж байна.

2013 оноос эхлэн орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан ажиглалтын системийг нэвтрүүлэх, ажиглалтын тоног төхөөрөмжийн хамрах хүрээг өргөтгөх, ажиглалтын системийн ашиглалтын зардлыг бууруулах, найдвартай ажиллагааг сайжруулах, олон улсын иргэний нисэхийн байгууллагаас бүс нутгийн хэмжээнд агаарын навигацийн үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор дэвшүүлэн тавьсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, концепцийг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/139 дугаар тушаалаар баталсан.

Тус төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор нийт 12 иж бүрдэл dual ADS-B станцыг суурилуулан ашиглаж байна.

Автомат хамааралтай ADS-B системийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөлгүй, бүсийн болон хөрш улс орнуудын төлөвлөгөөтэй уялдуулан аюулгүй ажиллагааны үнэлгээ, ADS-B системийн илрүүлэлтийн судалгаа, автомат системд илэрсэн үл нийцлүүдийг арилгах зэрэг нэлээдгүй ажлыг үе шаттайгаар хийж гүйцэтгэсний үр дүнд Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/169 дүгээр тушаалаар Автомат хамааралтай ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний удирдлагад нөхцөл байдлыг танин мэдэх зорилгоор ашиглаж эхэлсэн. Энэ ажлын үр дүнг үндэслэн 2018 оны 6 дугаар сард нислэгийн хөдөлгөөний удирдлагын зайчлалд Автомат хамааралтай ADS-B системийг ашиглаж эхлэхээр төлөвлөн Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/612 дугаар тушаалаар хэрэгжүүлэх ажлын хэсгийг томилсон.

Автомат хамааралтай ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний удирдлагын зайчлалд ашиглах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг нь Иргэний нисэхийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаар хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар Автомат хамааралтай ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний удирдлагын зайчлалд ашиглах ажлын төлөвлөгөөний биелэлт 100 хувь хангагдан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/322 дугаар тушаалаар Автомат хамааралтай ADS-B системийг нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын зайчлалд агаарын хөлгөөс нэмэлт тоноглол шаардахгүйгээр 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрөөс ашиглах тушаал гарсан.

Мөн Нисэхийн мэдээллийн эмхэтгэлийн 01/2018 AIRAC Supplement бүтээгдэхүүнээр 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 0000 UTC цагаас эхлэн Монгол Улсын агаарын зайд ADS-B системийг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажиглалтын зайчлалд ашиглахаар зарлан мэдээлсэн боловч цар тахлын нөхцөл байдал, Зам, тээврийн хөгжлийн яамны Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанаас өгсөн 9 зөвлөмж, Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын албаны байцаагчийн 7 дүгнэлттэй холбоотой 01/2021 AIRAC Supplement бүтээгдэхүүнээр 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 0000 UTC цагаас эхлүүлэхээр хойшлуулсан бөгөөд Монгол Улсын агаарын зайд ADS-B системийг Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажиглалтын зайчлалд бүрэн ашиглаж эхлэхтэй холбоотой Цар тахлын үед ажиллах төлөвлөгөө, Нислэг техникийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанаас өгсөн 9 зөвлөмж, Нислэгийн аюулгүй ажиллагаа хяналт, зохицуулалтын албаны байцаагчийн 7 дүгнэлтийг залруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажилласны үр дүнд 01/2021 AIRAC Supplement бүтээгдэхүүнээр зарласны дагуу 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 0000 UTC цагаас эхлэн Монгол улсын агаарын зайн нислэгийн хөдөлгөөний ажиглалтын удирдлагын зайчлалд автомат хамааралтай ажиглалтын ADS-B системийг бүрэн ашиглаж эхэлсэн.



Автомат хамааралтай ажиглалтын систем (ADS-B)-ийн газрын станцын хамрах хүрээг сайжруулах судалгааг хийж, оновчтой байрлалд 2-ыг шилжүүлэн суурилуулах ажлын хүрээнд тайлан танилцуулгыг бэлтгэж Иргэний нисэхийн ерөнхий газрын даргатай Агаарын навигацийн үйлчилгээтэй холбоотой зарим асуудлыг хэлэлцсэн 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн хурлаар ИНЕГ болон Thales компанийн хооронд 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр байгуулсан ИНЕГ/ХОӨ/ТББ/Б-11/20 тоот гэрээний дагуу нийлүүлэгдсэн хос сувгийн 2 иж бүрдэл ADS-B AX-680 загварын газрын станцуудыг Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт байрлах 2К цамхаг болон БНХАУ-тай шинээр агаарын хаалга нээх бэлтгэл ажлыг хангаж Говь-Алтай аймгийн Цээл суманд байрлах шинэ өнгөрөлтийн цэгт, мөн Холбоо навигаци ажиглалтын албаны агуулахад байгаа дан сувгийн ADS-B станцуудыг нэгтгэж Говь-Алтай аймгийн Алтай нисэх буудалд гэсэн 3 байршилд суурилуулах байршилыг тодорхойлуулсан. Дээрх 3 байршилд 3 иж бүрдэл ADS-B станцыг суурилуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 5 дугаар сард багтаан суурилуулж, 2022 оны 9 дүгээр сард бүрэн үйл ажиллагаанд оруулсан.

Монгол Улс болон ОХУ-ын нисэхийн эрэн хайх, авран туслах чиглэлээр хамтарсан SAREX-2022 сургуулилтын бэлтгэлийг хангаж, оролцох ажлын хүрээнд Монгол Улс болон ОХУ-ын нисэхийн эрэн хайх, авран туслах чиглэлээр бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулсан бөгөөд манай талаас ОХУ-д тус чиглэлээр мэйлүүд хүргүүлсэн боловч албан ёсны хариу ирээгүй. 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдөр ОХУ-ын Агаарын тээврийн агентлагаас ирсэн 201-01 дугаартай албан бичгээр тус хамтарсан сургуулилтыг зохион байгуулах боломжгүйг мэдэгдсэн.

***Агаарын навигацийн үйлчилгээнд дэвшилтэт техник, технологийн шинэчлэлтийг хийх талаар:***

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүд хоорондын мэдээллийг автоматжуулах AIDC /ATS Interfacility Data Exchange/ өгөгдлийг Улаанбаатар-Бээжин нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвүүд хооронд солилцож, бүрэн үйл ажиллагаанд оруулах ажлын хүрээнд AIRCON2100 автомат системд ACP, TOC, AOC мессежийг дамжуулах удирдлагыг нислэгийн удирдагчдад ажлын ачаалал үүсгэхгүй, алдаа дутагдал гаргахгүй байхаар техникийн даалгаврыг боловсруулан үйлдвэрлэгчтэй зөвшилцсөн. Тус системийн өөрчлөлтийг ASA гэрээний хүрээнд 57,000 (евро)-р хийх үнийн саналыг үйлдвэрлэгчээс ирүүлсний дагуу гэрээнд өөрчлөлт оруулж байгуулсан. Үйлдвэрлэгчийн зүгээс AIDC системийн ашиглалтыг хангахтай холбоотой программ хангамжийн өөрчлөлтийг 2022 оны 10 сарын 24-ны өдөр AIRCON 2100 системд оруулах төлөвлөлт ирүүлсний дагуу программ хангамжийн өөрчлөлтийг хугацаанд нь хийж, 2022 оны IV дүгээр улиралд багтаан үйл ажиллагаанд ашиглаж эхлэхээр ажиллаж байна.

Монголын агаарын навигацийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ /VPN/ байгуулах ажлын хүрээнд: ИНҮТ-ийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд “Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын шинэ төвийн агаарын навигацийн үйлчилгээний тоног төхөөрөмж, систем” байгуулахад 3.9 тэрбум төгрөг тусгагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдөр ИНЕГ/202104013 дугаартай “Агаарын навигацийн үйлчилгээний мэдээлэл дамжуулах IP технологид суурилсан сансрын холбооны систем нийлүүлэх” тендер зарлаж, “Ай Ти Зон” ХХК-тай 2021 оны 09 дүгээр сарын 08-нд гэрээ байгуулсан. Гэрээний дагуу “Ай Ти Зон” ХХК-аас 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр тоног төхөөрөмжийг нийлүүлж тус газрын харъяа холбоо, навигацийн ажиглалтын албаны инженер техникийн бүрэлдэхүүн 7 багаар 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 22-ны өдрүүдэд ажиллаж /Чойбалсан, Их-Өлгий, Сайхандулаан, Сайншанд, Баянтээг, Далан, Бөмбөгөр, Ургамал, Улиастай, Булган, Өлгий, Мөнх-Өлзийт, Хэнгэрэгтэй, Өндөрхаан, Улаангом, Мөрөн, Даланзадгад, Алтай, Ховд, Тосонцэнгэл, Арвайхээр, Ховдын Булган, Бор-Өндөр, Мандалговь/ 24 алслагдсан станцын суурилуулалтыг батлагдсан төлөвлөгөөний дагуу амжилттай хийж ашиглалтад оруулаад байна.

Төлөвлөгөөний 2-р үе шат болох агаарын навигацийн үйлчилгээний нэгдсэн VPN сүлжээг зохион байгуулахаар орон нутгийн 22 байршилд Иргэний нисэхийн үндэсний төвийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв хооронд агаарын навигацийн мэдээлэл дамжуулах зориулалт бүхий VPN сүлжээний зохион байгуулахад шаардлагатай MPLS сүлжээний үйлчилгээ авах техникийн даалгавар боловсруулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг амжилттай зохион байгуулсан ба үйлчилгээ үзүүлэгчээр Мобиком ХХК шалгарсан. Удирдлага хяналтын төвд VPN тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулах, цахилгаан тэжээлд холбож, ажиллагааг шалгах, MPLS шугамаар алслагдсан байгууламжуудтай холболтыг шалгах ажлыг бүрэн гүйцэтгэж дууссан. Хэнтий нисэх буудалд IP RCAG, AirFiber, VPN тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулах, Мобиком ХХК-ийн түрээсийн MPLS шугамаар VPN сувгийг үүсгэж ажиллагааг турших, IP RCAG станцуудыг VPN сувгаар дуун холболтын IP VCS төхөөрөмжид холбож ажиллагааг шалгах, агаарын навигацийн үйлчилгээний бусад тоног төхөөрөмжүүдийг (AFTN, ADS-B, Analog RCAG) холбож турших ажлуудыг 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдрүүдэд гүйцэтгэж дууссан. Нийт 23 байрлал болон байгууламжид тус тус суурилуулалт хийж, туршилт шалгалтаар



ажиллуулах ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу агаарын навигацийн байгууламжуудын хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүйгээр нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн ханган ажиллаж байна.

Ази Номхон далайн бүсийн орнуудын нэгдсэн CRV сүлжээнд холбогдож мэдээлэл солилцох, үйл ажиллагаанд ашиглах ажлын хүрээнд ICAO-ын APANPIRG ажлын хэсгийн CRV/OG09 группийн хуралдаанд "Монгол Улсын CRV хэрэгжилт, тулгамдаж буй асуудал" сэдэвт мэдээлэл, танилцуулга бэлтгэн 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 27-ны өдрүүдэд оролцсон. Үйлчилгээ үзүүлэгч PCCW GLOBAL компанитай гэрээний нөхцөлийг нарийвчлан тохиролцож техникийн даалгаврыг боловсруулсан. CRV сүлжээнд холбогдож мэдээлэл солилцох, үйл ажиллагаанд оруулахтай холбоотой нарийвчилсан төлөвлөгөөг бусад технологийн шинэчлэлийн ажилтай нэгтгэн гаргаж батлуулсан.

AMHS системийн үйлдвэрийн дадлага, сургалтын үйл ажиллагаанд нийт 10 инженер техникийн ажилтан хамрагдсан. Үйлдвэрлэгчээс томилогдсон инженер техникийн ажилтнуудтай хамтран нийлүүлэгдсэн AMHS системийн суурилуулалт, хэмжилт, тохируулгын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. AMHS системийг нислэгийн хөдөлгөөний үйл ажиллагаанд ашиглах нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр AFTN хэрэглэгчдийн нэгдсэн хурал, семинарыг АНҮГ-аас зохион байгуулсан. Төлөвлөгөөний дагуу төвийн хэрэглэгчид 2022 оны IV удиралд багтан AMHS системд холбогдох ба орон нутгийн нисэх буудлууд 2023 оны I улиралд AMHS системд холбогдохоор төлөвлөгөөнд тусгагдсан.

Нислэгийн хөдөлгөөний удирдлагын байранд суурилуулсан Freguentis AG компанийн үйлдвэрлэсэн VSC3020X маркын дуун холбооны системийг туршилт шалгалтаар ажиллуулах ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу агаарын навигацийн байгууламжуудын хэвийн ажиллагаанд нөлөөлөхгүйгээр нислэгийн аюулгүй ажиллагааг бүрэн хангаж хийж гүйцэтгэсэн. 2022 оны 06 дугаар сарын 20-ноос 29-ний өдрүүдэд нислэгийн удирдагч нарт Freguentis AG компанийн үйлдвэрлэсэн VSC3020X маркын дуун холбооны системийн ашиглалтын сургалтыг зохион байгуулсан.

Алсын удирдлагатай хэт богино долгионы /IP RCAG/ радио станцын суурилуулах төлөвлөгөөг бусад технологийн шинэчлэлийн ажилтай нэгтгэн, 9 газарт суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэн, үйлдвэрлэлд ашиглаж байна. Өвөрхангай, Дорнод, Дорноговь аймаг, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн 162-р релейний станц, Хөвсгөл аймгийн Хэнгэрэгтэй, Завхан аймгийн Ургамал, Говь-Алтай, Хэнтий дэх нийт 9 нисэхийн байгууламжид алсын удирдлагатай хэт богино долгионы радио станцуудыг (IP RCAG), Нислэгийн хөдөлгөөний удирдлагын төвд алсын удирдлага хяналтын системийг (RCMS) суурилуулалт хийгдсэн. Туршилт шалгалтын ажлыг гүйцэтгэх үйл ажиллагааг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 08 дугаар сарын 15 -ны өдрийн хооронд гүйцэтгэсэн. Шинэчлэн суурилуулсан VSAT систем болон шилэн кабелийн VPN сүлжээгээр дамжуулах байгууламжийг зохион байгуулж туршилтын ажил хийгдсэн.

#### **Агаарын зайн менежментийн оновчтой тогтолцоог бүрдүүлэх талаар:**

Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ICAO)-ын Ази номхон далайн бүсийн орнуудын APANPIRG/27/12, ATM/SG/7-5 хурлаас гарсан шийдвэрүүд, ICAO-ын Хавсралт 10 Боть II, Док 8585 "Designators for Aircraft Operating Agencies, Aeronautical Authorities and Services", Док 4444 "Procedures for air navigation services - Air Traffic Management" баримт бичигт 11.2.1.2.3.3 заалтын заасны дагуу Нислэгийн төлөвлөгөө болон ATS мессежнүүдийн мэдээ дамжуулах AFTN хаягуудын routing table-г шинэчлэх судалгааг хийж, төлөвлөгөө гарган батлуулах ажлын хүрээнд AFTN GROUP хаягуудад өөрчлөлт оруулан, Монгол Улсын AIP-ын хэсэг ENR 1.11-ийн мэдээллийг шинэчлэн 2022 оны 3 дугаар сарын 10-ны өдөр хэвлэгдэх 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр хүчин төгөлдөр болох AIRAC AIP AMDT 03/22 бүтээгдэхүүнээр хэвлэн нийтэлсэн. Үүний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ:

Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ICAO)-ын Ази номхон далайн бүсийн орнуудын APANPIRG/27/12, ATM/SG/7-5 хурлаас гарсан шийдвэрүүдэд үндэслэн ENR 1.11 НИСЛЭГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ МЭДЭЭГ ХАЯГЛАН ЯВУУЛАХ хэсгийн AFTN хаягуудыг шинэчлэх ажлын хүрээнд ХНД-ийн нислэгт (ZMUBZRZX, ZMUBZRZA, ZMUBZRZB ZMUBZQZX, ZMUBZRZQ, ZMUBYAYX ZMUBZTZ, ZMUBZGZX) хаягуудын оронд ZMUBZGZX хаягийг, ИХНД-ийн нислэгт (ZMUBZRZX, ZMUBZRZA, ZMUBZRZB ZMUBZQZX, ZMUBZRZQ, ZMUBYAYX ZMUBZFZX, ZMUBZLZX, ZMUBZTZ, ZMUBZGZX) хаягуудын оронд ZMUBZFZX хаяг болгон өөрчилсөн ба үүнтэй холбоотой AFTN routing table-д өөрчлөлт оруулсан.

ICAO Док 4444 "Procedures for air navigation services - Air Traffic Management"-н 11.2.1.2.3.3 заалт, ICAO-ын Хавсралт 10 Боть II болон Док 8585 "Designators for Aircraft Operating Agencies, Aeronautical Authorities and Services"-ын дагуу Нислэгийн мэдээллийн төв (Туул)-ийн ZMUBZLZX AFTN хаягийг ZMUBZIZX болгон өөрчилсөн.



ICAO-ын Хавсралт 10 Боть II болон ICAO Док 4444 "Procedures for air navigation services - Air Traffic Management"-н 11.2.1.2.3.3 заалтын дагуу Завхан/Отгонтэнгэр нисэх буудлын ZMUTZTX AFTN хаягийг ZMDNZTX болгон өөрчилсөн.

Энэ өөрчлөлтүүдийн талаар мэдээлэл хүргэх зорилгоор ИНҮТ-ийн Нисэх буудлуудын үйлчилгээний газар болон Завхан аймгийн Отгонтэнгэр нисэх буудалд 2022 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 10-7/174 тоот албан бичгийг Иргэний нисэхийн ерөнхий газарт 2022 оны 2 дугаар сарын 25-ны 10-1/243 тоот албан бичгийг, Холбоо,навигац,ажиглалтын албанд болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний албанд 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10-77/196 албан бичгийг, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанд 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10-7/197 тоот албан бичгийг тус тус хүргүүлсэн.

ICAO Circular -353 болон PANS-OPS DOC 8168 Vol II 1.4.2.2, 1.4.2.5 заалтуудын дагуу Нислэгийн зургийн нэршлийг шинэчлэх судалгааг хийж, шинэчлэн AIP-аар хэвлэн нийтлүүлэх ажлын хүрээнд Нисэхийн мэдээллийн эмхэтгэлээр зарлагдсан ойртолт үйлдэх RNAV (GNSS) зургийн нэршлийг RNP болгох судалгааг гаргасан. Үүнд: Алтай, Чойбалсан, Чингис хаан, Буянт-Ухаа, Ховд, Мөрөн, Дэглий цагаан, Өлгий нисэх буудлуудын ойртолт үйлдэх (RNAV) 10 зургийн нэршилд өөрчлөлт оруулан Монгол улсын AIP-р хэвлэн нийтэлсэн.

Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн III үе шатны ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж АННББЗГ-т хүргүүлсэн. 2022 онд Монгол Улсын агаарын зайн цогц шинэчлэлийн хүрээнд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/10 дугаар "Агаарын зам шинэчлэн батлах тухай" тушаалаар Үзүүлэлтэд тулгуурласан навигаци (PBN)-ийн 6 агаарын замыг шинэчлэн тогтоож, 84 уламжлалт агаарын замыг 34 болгон нэгтгэсэн. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/10 дугаар "Агаарын зам шинэчлэн батлах тухай" тушаалын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ажлын төлөвлөгөөг боловсруулан ИНЕГ-ын даргаар 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдөр батлуулсан. Төлөвлөгөөний дагуу бэлтгэл ажлыг ханган Монгол улсын агаарын зайд цогц шинэчлэлийг 10 сарын 6-ны өдөр амжилттай нэвтрүүлж, Хил хязгааргүй нисэх-2030 нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан.

Агаарын замуудыг уян хатан (flexible), чөлөөт байдал (Free route)-аар ашиглах ерөнхий төлөвлөгөөний дагуу судалгааг хийх ажлын хүрээнд Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр баталсан "Агаарын зайн менежмент-Чөлөөт агаарын замыг нислэгийн хөдөлгөөний үйлчилгээнд нэвтрүүлэх ерөнхий төлөвлөгөө"-нд тусгагдсан 2022 онд хийж хэрэгжүүлэх дараах 8 агуулгаар судалгааг хийсэн. Үүнд:

- Нислэгийн урсгал төлөвлөлтийн менежмент (ATFM)-ийг хэрэгжүүлэх
- Олон улс болон Монгол Улсын эрх зүйн баримт бичгийг судлах
- Олон улсын туршлага судлах
- Агаарын зайн (FUA) дэвшилтэт уян хатан хэрэглээ ба бодит агаарын зайн мэдээллийн менежмент
- Чөлөөт агаарын зам (FRA)
- RNP агаарын зам
- Хэрэглэгчийн сонгосон маршрут (User preferred route)
- Нислэгийн урсгал, чиглэлд судлах

Си системийн бус хэмжлийн нэгжийг нислэгийн хөдөлгөөний удирдлагад нэвтрүүлэх ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг эхлүүлэх ажлын хүрээнд Агаарын навигаци-2025, Агаарын навигаци-2030 дунд болон урт хугацааны стратеги төлөвлөгөөнд саналыг тусгасан. ASA гэрээний техникийн даалгаварт тусган үйлдвэрлэгчтэй хийх гэрээнд оруулж баталгаажуулсан. Үйлдвэрлэгчийн зүгээс Си системийн бус хэмжлийн нэгжийг нислэгийн хөдөлгөөний удирдлагын системд оруулах ажлыг 2023 оны 1 сарын 27-ны өдөр туршилт хийхээр төлөвлөгөө ирүүлсэн. Үйлдвэрлэгчээс ирүүлсэн төлөвлөгөөт хугацаанд уялдуулан нислэгийн хөдөлгөөний удирдлагад Си системийн бус хэмжлийн нэгжийг нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөний төслийг боловсруулан ИНЕГ, АННББЗГ-т хүргүүлсэн.

#### ***Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний чиглэлээр:***

Монгол Улсын хяналтгүй агаарын зайд үйлдэгдэж буй Ерөнхий зориулалтын агаарын хөлгийн нислэг нэмэгдэж байгаатай холбогдуулан нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний зохицуулалтыг тодорхой болгох зорилготойгоор 2022 оны 5 дугаар сарын 27-ний өдөр Хяналтгүй агаарын зайд нислэг үйлдэх журмын хэлэлцүүлгийг Буянт-Ухаа НБ-д хийсэн.

МУ-ын Иргэний нисэхийн ерөнхий газрын "ХИЛ ХЯЗГААРГҮЙ НИСЭХ-2030" дунд хугацааны стратеги хэрэгжүүлэх төлөвлөгөөнд сансрын SB-ADSB-ийг үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр тусгагдсаны дагуу АНҮГ-аас "Сансрын SB-ADSB"-ийн талаар судалгаа боловсруулан ИНЕГ-ын дарга болон АННББЗГ-т 2022 оны 07 сарын 27-ний өдөр болон 08 сарын 15-ний өдөр танилцуулсан.



### **Нислэгийн урсгал төлөвлөлтийн чиглэлээр:**

Хил дамнасан нислэгийн урсгал төлөвлөлтийн менежментийг үе шаттайгаар хэрэгжүүлэхэд урт хугацааны болон урьдчилсан нислэгийн төлөвлөлтийг тогтмол хийж байна.

Бүс нутгийн болон хөрш улсуудын урсгал төлөвлөлтийн системүүдтэй мэдээлэл солилцох FIXM стандартад суурилсан өгөгдөл солилцооны бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Олон улс болон хөрш улсуудын систем, баримт бичгийг судлан, 2023-2025 онд FIXM-ийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулан 2022 оны 8 дугаар сарын 17-ны өдөр баталсан.

Монгол Улсын агаарын зайд үйлдэгдэж буй өнгөрөлтийн болон нисэх буудлуудад хөөрч, бууж буй агаарын хөлөгт нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээ үзүүлдэг. 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Монгол Улсын агаарын зайд нийт **46139** нислэг гүйцэтгэгдсэн байна. Үүнд: Олон улсын өнгөрөлтийн нислэг 33727, Олон улсын хөөрөлт, буулт 4433, Орон нутгийн нислэг 7979 байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Олон улсын өнгөрөлтийн нислэг -40.8%-иар буурсан, Олон улсын хөөрөлт, буулт 140.1%, Орон нутгийн нислэг 98.9% -иар тус тус өссөн дүнтэй байна. 2019 оны мөн үетэй харьцуулахад Олон улсын өнгөрөлтийн нислэг – 71.3%-иар, Олон улсын хөөрөлт, буулт -52.9%-иар тус тус буурсан, Орон нутгийн нислэг 13.5% -иар өссөн дүнтэй байна.

### **Холбоо, навигац, ажиглалтын үйлчилгээний чиглэлээр:**

Говь-Алтай аймгийн Цээл суманд байрлах Цээл олон улсын өнгөрөлтийн цэгийн байгууламжид шинээр нээх агаарын хаалга болон агаарын замуудын агаарын навигацийн үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор дараах тоног төхөөрөмжүүдийг суурилуулах арга хэмжээг авлаа. Үүнд:

- Алсын удирдлагатай 2 сувгийн хэт богино долгионы PAE T6 RCAG станц,
- Автомат хамааралтай ажиглалтын систем ADS-B станц

Тоног төхөөрөмжүүдийн суурилуулалтыг бүрэн хийж гүйцэтгэсний дараа сансрын холбоо болон газар шугамын дамжуулах байгууламжуудын тусламжтайгаар холболтыг хийж нислэг хөдөлгөөний удирдлагын төвтэй холбох ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн.

### **Ажиглалтын удирдлагын хамрах хүрээ /ads-b/**

Шинээр нээх агаарын хаалга болон агаарын замуудын ажиглалтын удирдлагын хамрах хүрээг сайжруулах зорилгоор авсан арга хэмжээний дүнд Монгол Улсын агаарын зайн 95 хувийг бүрэн хамрахуйц хэмжээний радио долгионы бүрхэлтийг үүсгэлээ.

### **Хэт богино долгионы радио холбооны хамрах хүрээ /rcag/**

Шинээр нээх агаарын хаалга болон агаарын замуудын дагуух хэт богино долгионы радио станцын хамрах хүрээг сайжруулах зорилгоор Говь-Алтай аймгийн Цээл сумын өнгөрөлтийн цэгийн байгууламжид 2 сувгийн RCAG станцын суурилуулалтыг ажлыг хийсэн ба ингэснээр Монгол Улсын агаарын зайг бүрэн хамрахуйц хэмжээний радио долгионы бүрхэлтийг үүсгэлээ.

### **Нисэхийн мэдээллийн үйлчилгээний чиглэлээр:**

Буянт-Ухаа нисэх буудал дахь Нисэхийн мэдээллийн үйлчилгээг Чингис хаан ОУНБ-аас үзүүлэх ИНУТ-ийн даргын шийдвэр гарсантай холбоотой нүүлгэлтийн төлөвлөгөөг гарган хэрэгжүүлж ажилласан ба эрсдэлийн үнэлгээг хийж эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч ажилласан. Мөн Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны “Үйл ажиллагааны ерөнхий заавар”-т холбогдох өөрчлөлтийг оруулан, үйл ажиллагаанд ашиглаж байна.

### **Боловсруулсан бүтээгдэхүүн, мэдээ /2022.11.16-ны байдлаар/**

| Утга                                |                      | Бүгд  |      |
|-------------------------------------|----------------------|-------|------|
| Олон улсаас хүлээн авсан нийт NOTAM |                      | 23584 |      |
| Зарласан NOTAM                      | А сери               | 738   |      |
|                                     | С сери               | 280   |      |
|                                     | SNOWTAM              | 81    |      |
| Боловсруулсан                       | 2D график NOTAM      | 423   |      |
|                                     | 3D график NOTAM      | 214   |      |
|                                     | Олон улсын чиглэл    | НӨМТ  | 1417 |
|                                     | Орон нутгийн чиглэл  |       | 2975 |
| Чингис хаан ОУНБ-аас хөөрсөн        | Нислэгийн төлөвлөгөө | 3389  |      |
|                                     | Хөөрөлт              | 3371  |      |
| Чингис хаан ОУНБ-д буусан           | Нислэгийн төлөвлөгөө | 3378  |      |
|                                     | Буулт                | 3377  |      |





|  |                      |      |
|--|----------------------|------|
| Буянт-Ухаа ОУНБ-аас хөөрсөн                            | Нислэгийн төлөвлөгөө | 1997 |
|  | Хөөрөлт              | 1986 |
| Буянт-Ухаа ОУНБ-д буусан                               | Нислэгийн төлөвлөгөө | 1986 |
|  | Буулт                | 1979 |
| AIRAC AIP AMDT 02/22-12/22                             |                      | 11   |
| AIP AMDT 01/22-09/22                                   |                      | 9    |
| AIRAC AIP SUP 01/22, 02/22                             |                      | 2    |
| AIP SUP 01/22, 02/22                                   |                      | 2    |
| C серийн AIC 01/22                                     |                      | 1    |
| Бүс-2-ын газрын гадаргын өгөгдлийн багцын бүтээгдэхүүн |                      | 23   |
| Бүс-3-ын газрын гадаргын өгөгдлийн багцын бүтээгдэхүүн |                      | 7    |
| Бүс-2 болон Бүс-3-ын саадын багц бүтээгдэхүүн          |                      | 21   |
| AIP-ын өгөгдлийн багц                                  |                      | 12   |
| Хэрэглэлийн нислэгийн журмын өгөгдлийн багц            |                      | 1    |
| Аэродромын зураглалын өгөгдлийн багц                   |                      | 3    |
| Хяналттай зураг  |                      | 287  |

### **Гэрэл, суулт цахилгаан хангалтын чиглэлээр:**

#### **Гэрэл суултын чиглэлээр:**

Ховд нисэх буудлын одоо байгаа гэрэл суулт болон PAPI систем зурвасын хажуугийн ирмэгээс зай нь зөрсөн байгааг “Аэродромын төлөвлөлт ба ашиглалт”-ын техникийн баримт бичигт нийцүүлэн суурилуулах ажлын зураг төсөл, болон ажлын даалгаврыг дахин боловсруулж ИНУТ-ийн даргаар батлуулах арга хэмжээг авч ажилласан.

“Чингис хаан” ОУНБ-ын Гэрэл суултын алсын удирдлагын системийн GP, LLZ, CT, CT sub PC-нүүдэд шинэ SSD хардууд захиалан авсан, эдгээр хардуудыг үе шаттайгаар алсын удирдлагын программыг суулган тохиргоо хийж шинэчлэн сольж байна.

“Чингис хаан” ОУНБ-ын гэрэл суултын TEDL-1 хэлхээнээс буусан ашиглагдахгүй байгаа CCR- ийг TP-26 дэд өртөөнд авчран холболт угсралтыг хийн ажиллагаанд оруулж, сургалт дадлагаар ашиглах бололцоотой болгосон.

“Чингис хаан” ОУНБ-ын гэрэл суултын системийн схем зургийн хэлхээнүүдийг трассын дагуу дугаарлаж, хэлхээнүүдийг өнгөөр ялган шуурхай ажиллагааны болон засварын инженер техникийн ажилтнуудад бэлтгэж өгсөн. Одоо тухайн зураг схемүүдийг хэвлэлтэд өгөхөд бэлэн болгоод байна.

“Чингис хаан” ОУНБ-ын гэрэл суултын системүүдийн хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан бөгөөд оны эхнээс нийтдээ гэмтэл, дутагдал, засварын 74 лог нээж, хаасан. Нээлттэй лог байхгүй. Тус нисэх буудлын гэрэл суултын системийг 2304ц 38мин асааж ашигласан.

#### **Цахилгаан хангалтын чиглэлээр:**

ИНЕГ-ын хэмжээнд 2,672,450.35 кВтц эрчим хүчийг УБЦТС ТӨХК-аас худалдан авч, 543,921,197 төгрөгийн цахилгааны тооцоо хийсэн. 443кВа нарны цахилгаан станцын эрчим хүчний үйлдвэрлэлээр 507,022 кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 71,282,222 төгрөгийн хэмнэлт гаргасан байна.

Агаарын навигацийн тоног төхөөрөмжийн тасралтгүй тэжээлийн систем болон, холимог тэжээлийн систем, цахилгаан хангалт, дизель генератортай холбоотой 343 гэмтэл, саатлыг засварлаж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан.

Цахилгааны инженер техникийн ажилтнууд өөрсдийн шийдэл, нөөц бололцоогоор ATS бүхий шилжүүлэн залгах самбар 3 иж бүрдлийг угсарч, Нислэг удирдлагын хяналтын төв, Баянтээг болон Их-Өлгий радиолокаторын байгууламжийн 0.4кВ цахилгаан хангамжийн шугам сүлжээнүүдэд суурилуулан холбож, ашиглалтад оруулсан. Тухайн самбарт SATEC PM130 ухаалаг хэмжүүрийн төхөөрөмжийг суурилуулж холбосноор НХУТ-ийн ээлжийн ахлах инженерийн ажлын байрнаас төвийн тэжээлийн параметр үзүүлэлтүүдийг хянах боломжийг бүрдүүлсэн.

Нислэг удирдлагын хяналтын төвийн MST-80 UPS-үүд, Богд уулан дахь ALP-20K UPS, Мөнх-Өлзийт РЛБ-ын алсын хяналтын системүүдийг шинээр ажилд оруулж, цахилгааны ээлжийн ахлах инженерийн ажлын байрнаас хянадаг болгосон.

Нислэг удирдлагын хяналтын төвийн MST-80 UPS-үүд, Богд уулан дахь ALP-20K UPS, Мөнх-Өлзийт РЛБ-ын алсын хяналтын системүүдийг шинээр ажилд оруулж, цахилгааны ээлжийн ахлах инженерийн ажлын байрнаас хянадаг болгосон.

Төв аймгийн Сэргэлэн суман дахь 2К цамхагт ADS-B газрын станц суурилуулсантай холбогдуулан Богд уулын холимог тэжээлийн системд ашиглаж байсан P13.5 дизель генераторыг шилжүүлэн суурилуулж, АТүS M 6S автомат сэлгэн залгагч бүхий ачаалал шилжүүлэх самбарын схемийг өөрчлөн тоноглож, холболтууд хийж дизель генераторыг автомат ажиллагаанд оруулсан.



НХҮА-ны сургалт дадлагажуурыг “Буянт-Ухаа” ОУНБ-ын байранд шилжүүлэн нүүлгэсэнтэй холбогдуулж, цахилгаан тэжээлийн шугам сүлжээний угсралт холболтуудыг гүйцэтгэж ашиглалтад оруулсан.

ИНҮТ/ХО/НТШ/Б-21/21 дугаартай гэрээний дагуу нийлүүлэгдсэн 5 иж бүрдэл “Riello S3T 20kVa” тасралтгүй тэжээлийн төхөөрөмжийг ИНЕГ-ын даргын 2022-05-19 өдрийн А/142 дугаар тушаалын дагуу хүлээн авч Хэнгэрэгтэй, Мөнх-Өлзийт, Баянтээг, Их-Өлгий, Сайхандулаан радиолокаторын байгууламжуудад тус тус суурилуулж ашиглалтад оруулсан.

ИНҮТ-ийн даргын 2022 оны А/171 тоот “Инженерийн баг томилох тухай” тушаалын дагуу томилогдсон баг Богд уулын хэт богино долгионы станцын байран дахь холимог тэжээлийн системийн Distribution board самбарыг өөрчлөн сайжруулж суурилуулах ажлыг гүйцэтгэсэн.

Мөнх-Өлзийт радиолокаторын байгууламжаас татан буугдсан APC SURT 20K тасралтгүй тэжээлийн төхөөрөмжийг ХНАА-ны богино долгионы радио нэвтрүүлэх төвийн өрөөнд шилжүүлэн суурилуулж ашиглалтад оруулсан.

Дундговь аймаг дахь нисэх буудалд GEP33, Өвөрхангай аймаг дахь Далан өнгөрөлтийн цэгт KIPOR, Арвайхээр нисэх буудалд YANMAR дизель генераторуудыг тус тус шилжүүлэн суурилуулж, ашиглалтад оруулсан.

НХҮТ-ийн тасралтгүй тэжээлийн төхөөрөмж (UPS-1)-ийн батарейнуудыг иж бүрнээр нь шинэчлэн сольсон.

Бөмбөгөр, Сайхандулаан, Их-Өлгий, Бор-Өндөр радиолокаторын байгууламжууд, Богд уулын цахилгаан дамжуулах агаарын шугамуудын хэт хүчдэлийн хамгаалагчийг сольж шинэчилсэн.

НХҮТ-ийн агаарын навигацийн тоног төхөөрөмжүүдийг өөр өрөөнд нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд тасралтгүй тэжээлийн самбар суурилуулж, холбон тэжээл татах, хөргөлтийн систем шилжүүлэн суурилуулах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Цахилгаан эрчим хүчний тооцоо нь УБЦТС ТӨХК-д шилжиж байгаа “Aviation fuel”, ХХК болон “Мэргэ ван” ХХК-д схемийн өөрчлөлт хийж тоолуур суурилуулсан.

#### **Нисэх буудлын үйлчилгээний чиглэлээр:**

##### *Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам:*

Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 136 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан ИНАБЖ-ын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн ИНЕГ-т хүргүүлсэн. Хэрэгжилт 95%-тай байна.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗТХСайд бөгөөд Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн даргаар 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 97.8% байна.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 2022 оны 18 дугаар хурал ЗТХЯ дээр 2022.11.17-ны өдөр хуралдаж, Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хэлэлцэж 2 багц 3 шийдвэр гарсан. Үүнд:

- “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлыг олон улс орон нутгийн нислэгийн нөөц нисэх буудлаар ажиллуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан ИНЕГ-ын даргын 2022 оны А/20 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 25-ны өдрүүдэд нисэх буудлын аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийж хориотой хамгаалагдсан, хилийн хяналт шалгалтын бүсийг шинэчлэн тогтоосон.
- Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенцийн 17 дугаар хавсралт, Иргэний нисэхийн тухай хууль, Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам, Иргэний нисэхийн аюулгүй байдлын сургалтын нэгдсэн хөтөлбөр, ИНД-140 “Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт”-ийг үндэслэн “Иргэний нисэхийн аюулгүй үзлэгийн ажилтан болон зааварлагчийг үнэмлэхжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, ИНЕГ-ын даргаар 2022 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн А/105 дугаар тушаалаар батлуулсан.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын дэд дарга нарын баталсан “Чингис хаан олон улсын нисэх буудалд терроризмтой тэмцэх, мэдээллийн болон иргэний нисэхийн аюулгүй байдлын чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийх хамтарсан ажлын хэсгийн удирдамж”-ын дагуу Чингис хаан ОУНБ-д ажлын хэсэг 2022.09.05-өөс 2022.09.26-ны өдрүүдэд эрсдэлийн судалгаа хийж, үнэлгээний тайланг ИНЕГ, ТЕГ-ын удирдлагуудад танилцуулсан.

##### *Агаарын тээврийг хялбаршуулах журам:*

Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 137 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Агаарын тээврийг хялбаршуулах журам”-ын 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн ИНЕГ-т хүргүүлсэн. Журмын хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 95% байна.



Агаарын тээврийг хялбаршуулах, үйл ажиллагааг зохицуулах Зөвлөлийн 2022 оны 10 дугаар хурал ЗТХЯ дээр 2022.11.17-ны өдөр хуралдаж, Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар хэлэлцэж 3 багц 5 шийдвэр гарсан.

Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Нарийн бичгийн даргын ажлын албаны 2022 оны 01 дүгээр хуралдааныг 2022.02.15-ны өдөр цахим хурал зохион байгуулсан.

Агаарын тээврийг хялбаршуулах, үйл ажиллагааг зохицуулах Зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗТХСайд бөгөөд Иргэний нисэхийн аюулгүй байдлын Зөвлөлийн даргаар 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт жилийн эцсийн байдлаар 94.3% байна.

Төлөвлөгөөний 3.3 -д тусгагдсан "Чингис хаан" Олон улсын агаарын замын боомтын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө болон Алсын хараа- 2050" сургалтыг 2022.03.11- ний өдөр "Буянт –Ухаа" ОУНБ-д цахим болон танхим хосолсон сургалтыг ЧХОУНБ-ийн Боомтын Зөвлөлийн дарга, Хилийн цэргийн 0218 дугаар анги зохион байгуулж явууллаа. Мөн 2022.04.06-ны өдөр "Чингис хаан" ОУНБ-д хилийн хяналтын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан зорчигч бүртгэлийн үйл ажиллагаанд ажиглалт хийж, харьяа алба нэгжийн технологийн үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж хүргүүлж ажилласан.

Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах Зөвлөл"-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3-д тусгагдсан ажлын хүрээнд 2022 оны 5-р сарын 17-ны өдөр ОБЕГ-аас "Чингис хаан" ОУНБ-д "Газар хөдлөлт, гамшиг, гал түймэр" сэдэвт онолын болон дадлага сургуулилтыг амжилттай зохион байгууллаа.

*Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр:*

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 48 дугаар тушаалаар батлагдсан "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр /2016-2021/ нь дуусгавар болж, шинэчлэн боловсруулах шаардлагатай болсон. Тус хөтөлбөрийн хэрэгжилтэд ИНЕГ ДАА-аас хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 09/619 дугаартай албан бичгээр цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хугацааг сунгах хэрэгцээ, шаардлага байгаа эсэхийг тодорхойлон үнэлгээний дүгнэлт ИНУТ-д ирсэн. Хөтөлбөрийг шинэчлэн батлуулах ажлын хүрээнд нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж, хөтөлбөрийн төслийг боловсруулна.

"Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх зөвлөл"-ийн 2022 оны 04 дүгээр хурал 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдаж, "Агаарын хөлөг шувуу, мал, амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр (2022-2027)"-ийг батлуулах ажлыг зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Ч.Мөнхтуяа), Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан)-т үүрэг болгосон.

Тус хөтөлбөрийг ЗТХСайдаар батлуулахаар ИНЕГ-ын даргын 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01/1777 тоот албан бичгийг хүргүүлсэн. Батлагдах шатандаа байна.

*Нисэх буудлуудын хөгжлийн талаар:*

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр менежментийг хэрэгжүүлэх 8 нисэх буудлын зардал, үр ашгийн тооцоолол хийж ИНЕГ-ын Даргын зөвлөлд 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр танилцуулсан. Орон нутгийн 8 нисэх буудлыг Орон нутгийн захиргаанд шилжүүлэх судалгаа танилцуулга бэлтгэж. 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр ИНЕГ-ын Даргын зөвлөлд танилцуулсан.

ЗТХЯ-ны 2022 оны 07 дугаар сарын 08 -ны өдрийн 03/3247 тоот албан бичгээр өгөгдсөн үүргийн дагуу /Мөрөн, Ховд, Чойбалсан, Гурвансайхан, Дэглийцагаан, Өндөрхаан, Хатгал, Хархорин, Хужирт, Өлгий, Дэлүүнболдог/ 11 нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулах судалгааг хийн, тайлан танилцуулгыг ИНЕГ-т 2022 оны 07 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлсэн.

Орон нутгийн нисэх буудлуудын ашиглалтыг сайжруулах, төр хувийн хэвшлийн түншлэлээр ашиглах тооцоо судалгаа шинэчлэн боловсруулж, 2022 оны 06 дугаар сарын 03-ны 01/998 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Мөрөн, Ховд, Чойбалсан, Гурвансайхан, Дэглийцагаан, Өндөрхаан, Хатгал, Хужирт, Хархорин нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулах төслийн хөрөнгө оруулалт, борлуулалт, зардал, үр ашгийн тооцоолол, Өлгий, Дэлүүнболдог болон бусад нисэх буудлуудын цаашдын ашиглалтыг сайжруулах судалгааг хийж, тайлан, танилцуулгыг 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 01/1353 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

Орон нутгийн нисэх буудлуудын аэродром орчмын тусгай бүсийг улсын тусгай хэрэгцээнд авах талаарх танилцуулга материалыг бэлтгэж ИНЕГ-ын даргад 2022 оны 03 дугаар сарын 10-ны өдөр танилцуулсан. Мөн Зам, тээврийн хөгжлийн яамны АТБЗГ-т танилцуулагдаж БХБЯ-нд шилжүүлсэн. БХБЯ-аас орон нутгийн 20 нисэх буудалтай орон нутгийн Засаг захиргаатай хэлэлцэхээр тогтсон.



ИНЕГ-ын даргын 2022 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Орон нутгийн нисэх буудлуудын орон тоог батлах” тухай А/104 дүгээр тушаалаар орон нутгийн нисэх буудлуудын орон тоо шинэчлэн батлагдсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын Даргын зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 12 дугаар шийдвэр, Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/192 дугаар “Сул зогсолт зарлах тухай” тушаалын төсөл зарим орон нутгийн нисэх буудлуудыг сул зогсолт хэсэгчлэн зарласан ажлын байрны жагсаалтын судалгаа болон сул зогсолтын үеийн орон нутгийн нисэх буудлуудын ажилтнуудын ажил үүргийн зохицуулалтын төслийг боловсруулан ИНЕГ-ын даргын зөвлөл, ИНҮТ-ийн даргын зөвлөлд тустус танилцуулсан. Дээрх шийдвэр тушаалын дагуу 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал орон нутгийн 15 нисэх буудалд сул зогсолт зарласан.

БУОУНБ-ыг НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр ашиглах төслийн танилцуулгыг боловсруулан 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/312 тоот албан бичгээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.

НҮБ-ын хүмүүнлэгийн тусламжийн чиглэлээр ашиглах боломжийн талаар ИНЕГ, Зам, тээврийн хөгжлийн яам, НҮБ-тай зөвшилцөх уулзалтыг 2022 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудалд зохион байгуулсан. Мөн БУОУНБ-д нисэхийн сургалтын төв болон хүмүүнлэгийн хариу арга хэмжээний төв байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 01/1655 тоот албан бичгээр ЗТХЯ-ны ИНБХЗГ-т хүргүүлсэн.

ИНҮТ-ийн “Үйл ажиллагааны ерөнхий заавар”-ыг боловсруулах ажлын хүрээнд Нисэх буудлуудын үйлчилгээний талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Нисэх буудлын үйлчилгээний газрын мэргэжилтнүүдийн ажлын чиг үүргийн судалгаа хийсэн.

Нисэх буудлын үйлчилгээний хөгжлийн алсын хараа, зорилт зорилго, стратеги зорилтыг тодорхойлж, төслийг ажлын хэсэгт хүргүүлсэн.

Хүний нөөцийн цаашдын хэрэгцээ хандлагыг тодорхойлох судалгаа боловсруулах ажлын хүрээнд “Нисэх буудлуудын үйлчилгээний газрын 2022-2030 он хүртэлх хүний нөөцийн төлөвлөлт”-ын судалгааг боловсруулсан.

Намар-өвлийн ашиглалтаас хавар-зуны ашиглалтад шилжүүлсэн Навигацийн үзлэг шалгалтыг 2022 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хооронд зохион байгуулж, орон нутгийн нисэх буудлуудын үр дүн, тайланг ИНЕГ-ын даргад 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Төвийн салбар нэгжийн үзлэг шалгалтын үр дүнг ИНЕГ-ын даргад 2022.06.30-ны өдөр танилцуулсан бөгөөд 16 үүрэг даалгавар өгссөнөөс 15-100%, 1-70% хэрэгжсэн.

ИНҮТ-ийн даргын 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 10-1/596 дугаар тушаалаар ИНҮТ-ийн 2022-2023 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн байдлаар 98.7%

ИНҮТ, “Эй Си Эйч Сервисес” ХХК-ийн хоорондын ИНҮТ-22/2022 тоот “Хамтран ажиллах гэрээ” 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр байгуулагдсан. Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, “МИАТ” ТӨХК хоорондын №22/139 тоот “Агаарын хөлгийн газрын үйлчилгээний тусгай зориулалтын автомашин, тоног төхөөрөмж түрээслүүлэх” гэрээг 2022 оны 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан.

ИНҮТ болон агаарын тээвэрлэгч нарын хооронд хээрийн түр зурвас сонгох харилцааг зохицуулах “Хамтран ажиллах гэрээ”-ний төслийг боловсруулан 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 4 агаарын тээвэрлэгчдэд хүргүүлсэн. Гэрээний төсөлд санал авах ажил хийгдэж байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 11-ны өдрийн А/112 дугаар тушаалаар “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үзүүлэх үйлчилгээний хураамжийг баталсан. Орон нутгийн нисэх буудлын газрын үйлчилгээний тарифын тооцооллыг хийсэн. ИНЕГ-ын АТБЗГ-т 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн ИНҮТ-ийн даргын 10-1/842 тоот албан тоотор хянуулахаар хүргүүлсэн.

#### **Гэрчилгээжүүлэлт:**

*Иргэний нисэхийн дүрэм -139*

| д/д   | Нисэх буудал  | Аэродромын хяналтын код | Аэродромын ерөнхий заавар боловсруулалтын байдал | Гэрчилгээний хүчинтэй хугацаа |
|---|---------------|-------------------------|--|-------------------------------|
| Иргэний нисэхийн дүрэм-139.5-ийн дагуу гэрчилгээжүүлэх болон гэрчилгээ эзэмшиж буй нисэх буудал |               |                         |  |                               |
| 1   | Ховд          | ЗС                      | Батлуулсан.                                      | 2023.05.30                    |
| 2   | Өлгий         | ЗС                      | Батлуулсан.                                      | 2023.04.30                    |
| 3   | Дэглий цагаан | ЗС                      | Батлуулсан.                                      | 2024.11.30                    |
| 4   | Алтай         | ЗС                      | Батлуулсан.                                      | 2023.04.01                    |
| 5   | Баянхонгор    | ЗС                      | Батлуулсан.                                      | 2024.07.31                    |



|   |              |    |                      |                       |
|---|--------------|----|----------------------|-----------------------|
| 6   | Отгонтэнгэр  | 3С | Батлуулсан.          | 2023.08.31            |
| 7   | Мөрөн        | 3С | Батлуулсан.          | 2023.11.30            |
| 8   | Гурвансайхан | 3С | Батлуулсан.          | 2023.04.01            |
| 9   | Чойбалсан    | 3С | Батлуулсан.          | 2024.07.15            |
| Иргэний нисэхийн дүрэм-139.417-ийн дагуу хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмших нисэх буудал |              |    |                      |                       |
| 1   | БУОУНБ       | 4D | Батлуулсан.          | 2022.12.31            |
| 2   | Арвайхээр    | 3С | Батлуулсан..         | 2023.06.30            |
| 3   | Баруун-Урт   | 3С | Батлуулсан.          | 2022.12.31            |
| 4   | Булган       | 3С | НААХЗА-д хүргүүлсэн. | Шинээр гэрчилгээжнэ.  |
| 5   | Өндөрхаан    | 3С | Хойшлогдсон          | Шинээр гэрчилгээжнэ.  |
| 6   | Тосонцэнгэл  | 3С | Батлуулсан.          | 2023.06.30            |
| 7   | Мандалговь   | 2С | Батлуулсан.          | 2023.02.15            |
| 8   | Булган сум   | 2С | Батлуулсан.          | Гэрчилгээгүй аэродром |

## Иргэний нисэхийн дүрэм -140

| №  | Гэрчилгээ эзэмшдэг байгууллагуудын нэр | Гэрчилгээний дугаар | Гэрчилгээний хугацаа | Тайлбар            |
|----|--|---------------------|----------------------|--------------------|
| 1  | АБХА                                   | 140-21              | 2023.05.12           | Салбарын гэрчилгээ |
| 2  | Гурвансайхан НБ                        | 140-03              | 2022.09.01           |                    |
| 3  | Отгонтэнгэр НБ                         | 140-04              | 2023.09.01           |                    |
| 4  | Ховд НБ                                | 140-05              | 2023.11.01           |                    |
| 5  | Чойбалсан НБ                           | 140-06              | 2022.06.01           |                    |
| 6  | Мөрөн НБ                               | 140-08              | 2023.09.28           |                    |
| 7  | Алтай НБ                               | 140-12              | 2022.09.01           |                    |
| 8  | Баянхонгор НБ                          | 140-14              | 2022.09.03           |                    |
| 9  | Өлгий НБ                               | 140-15              | 2023.11.30           |                    |
| 10 | Дэглий цагаан НБ                       | 140-17              | 2022.06.15           |                    |

## Иргэний нисэхийн дүрэм -144

ИНҮТ-ийн МСАА.144.008/20 тоот гэрчилгээ 2022 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 2 жилийн хугацаагаар сунгагдсан ба хавсралтаар төвийн 2 нэгж болон 11 нисэх буудал гэрчилгээжсэн байна. "БАЯНХОНГОР", "МАНДАЛГОВЬ", "ӨНДӨРХААН" "Баруун-урт" нисэх буудлууд хөрөнгө оруулалттай холбоотойгоор гэрчилгээжих боломжгүй байна.

| №  | Нисэх буудал                 | Гэрчилгээний хүчинтэй хугацаа | Ерөнхий заавар батлагдсан эсэх /шинэчлэн батлагдсан инд-144/ |
|----|------------------------------|-------------------------------|--|
| 1  | ЧХОУНБ дахь ШХА              | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 2  | ИНҮТ ГТҮШХА шатахууны хэлтэс | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 3  | "Алтай"                      | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 4  | "Өлгий"                      | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 5  | "Гурвансайхан"               | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 6  | "Отгонтэнгэр"                | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 7  | "Дэглий цагаан"              | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 8  | "Мөрөн"                      | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 9  | "Ховд"                       | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 10 | "Чойбалсан"                  | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |
| 11 | "Баянхонгор"                 | Гэрчилгээ аваагүй             | Батлагдсан   |
| 12 | "Булган"                     | 2022.05.24-2024.05.24         | Батлагдсан   |



|    |               |                       |            |
|----|---------------|-----------------------|------------|
| 13 | “Тосонцэнгэл” | 2022.05.24-2024.05.24 | Батлагдсан |
| 14 | “Өндөрхаан”   | Гэрчилгээ аваагүй     | Батлагдсан |
| 15 | “Баруун-урт”  | Гэрчилгээ аваагүй     | Батлагдсан |
| 16 | “Мандалговь”  | Гэрчилгээ аваагүй     | Батлагдсан |
| 17 | “Арвайхээр”   | 2022.05.24-2024.05.24 | Батлагдсан |

**Аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааны чиглэлээр:**

Аюулгүй байдал, хамгаалалтын алба бие даан Иргэний нисэхийн дүрэм 140-ийн дагуу НААХЗА-аас 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдрөөс гэрчилгээжүүлэлтийн үзлэг шалгалт хийгдэж 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдөр ИНД-140-21 дугаартай гэрчилгээг 1 жилийн хугацаатай буюу 2023.05.03-ны өдрийг дуустал гэрчилгээжсэн.

ИНД-140 ИНД-140 дагуу Аюулгүйн хамгаалалттай аэродромын жагсаалтад тусгагдсан дараах нисэх буудлуудын гэрчилгээний хугацааг сунгуулах ажлыг зохион байгуулсан. Үүнд:

1. “Баянхонгор” нисэх буудлын ИНД-140 гэрчилгээг 2022 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл,

2. “Чойбалсан” НБ-ын ИНД140-06 дугаартай гэрчилгээг 2023 оны 06 дугаар сарын 01-ийг өдрийг хүртэл,

3. “Дэглий цагаан” НБ-ын ИНД140-17 дугаартай гэрчилгээг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл,

4. “Гурвансайхан” НБ-ын ИНД140-ийн гэрчилгээг 2024 оны 03 дугаар сарын 01-ийг өдрийг хүртэл,

5. “Алтай” НБ-ын ИНД140-ийн гэрчилгээг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл.

6. “Отгонтэнгэр” НБ-ын ИНД140-ийн гэрчилгээг 2023.09.01-ийг өдрийг хүртэл сунгуулсан.

Дорнод аймгийн Чойбалсан ОУНБ, Ховд аймгийн Ховд нисэх буудал, Баян-Өлгий аймгийн Өлгий нисэх буудалд, Терроризмтэй тэмцэх арга хэмжээ болон иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хийсэн эрсдэлийн үнэлгээний зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх эрсдэлийг бууруулах, учрах хохирлыг багасгах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг нэгтгэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 136-р тогтоолын хавсралтаар шинэчлэн батлагдсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-д орсон өөрчлөлт болон Завхан аймгийн “Доной” нисэх буудлын оноосон нэр “Отгонтэнгэр” болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус нисэх буудлын “Аюулгүй байдлын хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулахад мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Иргэний нисэхийн аюулгүй байдлын зөвлөлийн 17 дугаар хурлын шийдвэр болон зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3 дахь хэсэгт заасан Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний Код-6, 7 “Агаарын хөлөг болон барилга байгууламжийг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээр заналхийлэх үйлдлийн үед авах хариу арга хэмжээ” сэдэвт дасгал сургуулилт зохион байгуулах ажлын хүрээнд Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудалд “Агаарын хөлгийг тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслээр заналхийлэх үйлдэл” /Код6/ онцгой нөхцөлийн төлөвлөгөөний хэсэгчилсэн дасгал сургуулилтыг 2022 оны 4 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд, Өвөрхангай аймаг дахь “Арвайхээр” нисэх буудалд “Агаарын хөлгийг булаан эзлэх үйлдэл /Код8/ сэдэвт онцгой нөхцөлийн төлөвлөгөөний ширээний дасгал сургуулилтын 2022 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд, Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудалд “Барилга байгууламжийг тэсрэх бодис тэсэлгээний хэрэгслээр заналхийлэх үйлдэл” /Код7/ онцгой нөхцөлийн бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг 2022 оны 4 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд бэлтгэл ажлыг ханган амжилттай зохион байгуулсан.

ИНҮТ, НУБИЭ ХХК хоорондын 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан ИНҮТ-52/2021 дугаартай Аюулгүй байдлын үйлчилгээний гэрээг НУБИЭ ХХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн SS-OP/1216 тоот албан хүсэлтийн дагуу дахин 1 сараар буюу 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаагаар сунгуулсан.

ИНЕГ-ын даргын 2022 оны А/207 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан /2023 онд Монгол Улсад хийгдэх ICAO-ын Universal Security Audit Programme-Continuous Monitoring Approach /USAP CMA/ аудитад шалгуулах бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

Ховд аймагт анх удаа ОХУ болон агаарын цэргийн 337-р ангитай хамтран байлдааны бүрэн хэмжээний СЭЛЭНГЭ-2022 сургуулилт 2022 оны 07 дугаар сарын 23-наас 28-ны өдрийн хооронд явагдсан бөгөөд сургалтад ОХУ-н МИ8-8, М1171-1, М26-6 нийт 15 агаарын хөлөгт газрын болон аэронавигацийн үйлчилгээг амжилттай үзүүлж ажилласан.

**Тээвэр зохион байгуулалт, зорчигч үйлчилгээний чиглэлээр:**

ИНЕГ-ын Цагийн хуваарийн зөвлөл 2022 оны 02 дугаар сарын 16-ны өдөр хуралдаж, Олон улсын болон орон нутгийн 2022 оны зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хэлэлцэж, баталсан. Цагийн хуваарийн зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдөр ээлжит бус хурлаар 2022 оны зуны хуваарьт нислэгийн цагийн хуваарийг хэлэлцэж, шинэчлэн баталсан.



Олон улсын зуны цагийн хуваарьт 5 удаагийн, орон нутгийн хуваарьт 2 удаагийн өөрчлөлт орсныг цаг тухайд нь Иргэний нисэхийн харьяа байгууллагууд болон агаарын тээвэрлэгч нарт хүргүүлэн ажиллаж байна

Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах Зөвлөл"-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.5-д тусгагдсан ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх "СОС" сургалтыг "Зүүн бүс" буюу "Чойбалсан" нисэх буудалд 2022.04.06-07, Төвийн бүс буюу "Арвайхээр" нисэх буудалд 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр, "Зүүн бүс" буюу "Алтай" нисэх буудалд 2022 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр тус аймгуудын Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсан.

Агаарын тээврийг хялбаршуулах үйл ажиллагааг зохицуулах Зөвлөл"-ийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 3.3-д тусгагдсан ажлын хүрээнд 2022 оны 5-р сарын 17-ны өдөр ОБЕГ-аас "Чингис хаан" ОУНБ-д "Газар хөдлөлт, гамшиг, гал түймэр" сэдэвт онолын болон дадлага сургуулийг амжилттай зохион байгууллаа.

Зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем /APIS/-ийн хуучин дата форматын хугацаа дуусаж шинэ форматаар буюу UN-EDIFACT PAXLST /Annex 9-ын стандарт/-ын дагуу дамжуулалт хийгдэхээр болсон. 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс энэхүү шинэчлэгдсэн форматаар мэдээлэл хүлээн авах /MQ setup/, датаг хувиргах програм хөгжүүлэлтийн /API gateway/ үндсэн системийг "Буянт-Ухаа" нисэх буудлаас мэдээлэл дамжуулалт хийгддэг байсныг "Чингис хаан" ОУНБ-д шилжүүлж Хилийн хяналтын байгууллагуудыг бүрэн холбосон.

"Нисэх буудлуудын үйлчилгээний газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний 5.3-д "Нисэх буудлын үйлчилгээний ерөнхий заавар"-ын хэрэгжилтийг ОННБ-дад хангуулж ажиллах талаар төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу орон нутгийн нисэх буудлуудын 2022 онд Зорчигч үйлчилгээний чиглэлээр шинээр хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэсэн.

"Нисэх буудлуудын үйлчилгээний ерөнхий заавар /УЗ-002:2021" -г боловсруулан батлуулж, орон нутгийн нисэх буудлуудад цахимаар хүргүүлсэн. Тус зааврын шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулахад орон нутгийн нисэх буудлын ажилтнуудад хүндрэлтэй асуудал байгаа эсэх талаар судалгаа авч судалгааны үр дүнд шинжилгээ хийн зөвлөмж хүргүүлсэн. Орон нутгийн нисэх буудлуудад "Нисэх буудлын үйлчилгээний ерөнхий заавар"-ыг байнгын хэрэгжилттэй байлгах зорилгоор Навигацийн үзлэг шалгалтын асуулгад нэмэлтээр асуумж бэлтгэн оруулсан. Орон нутгийн нисэх буудлуудад "Агаарын тээврийг хялбаршуулах журам" болон "Нисэх буудлуудын үйлчилгээний ерөнхий заавар", Орон нутгийн нисэх буудлуудын ажилтан албан хаагчдаас үйлчилгээний зааврын талаар авсан судалгааны үр дүнгийн талаарх танилцуулга сургалтыг 2022 оны 05 дугаар сарын 07-ны өдөр цахимаар зохион байгуулсан.

Орон нутгийн нисэх буудлуудаар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол нислэгтэй 6 нисэх буудлаас авч боловсруулалт хийсэн бөгөөд үр дүнг ХЭЗХАГ-д 2022 оны 03 дугаар сарын 04-нд цахимаар хүргүүлсэн.

Баян-Өлгий аймаг дахь Өлгий нисэх буудалд Буянт-Ухаа Олон улсын нисэх буудлаас буулгасан Герман улсад үйлдвэрлэгдсэн зорчигчийн ачаа, тээшний туузан дамжуургыг 2022 оны 6 дугаар сард татан авч угсралтын ажлыг хийж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.

#### *Газрын тусгай үйлчилгээ шатахуун хангамжийн чиглэлээр:*

Нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор ОННБ-аас ИНЕГ-ын агаарын хөлгийн шатахууны нөөцөд 204,0 тонн шатахууныг төвлөрүүлэхээр тооцоолсоноос бүрэн татаж ЧХОУНБдШХА-ны шатахуун хадгалах саванд байршуулсан.

ИНЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн өргөтгөсөн шуурхайгаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд Хөвсгөл аймаг 5ш(50м3 2ш, 25м3 3ш), Булган аймаг 2ш(50м3 2ш), Тосонцэнгэл 2ш(50м3 2ш), Баян-өлгий 2ш(75м3 2ш) нийт 11 савыг консервацид хадгалах ажлыг зохион байгуулсан.

ИНҮТ-ийн МСАА.144.008/20 тоот гэрчилгээ 2024 оны 5 дугаар сарын 24-ний өдөр хүртэл 2 жилийн хугацаагаар сунгагдсан "Арвайхээр", "Тосонцэнгэл", "Булган" нисэх буудлуудыг ИНҮТ-ийн МСАА.144.008/20 дугаартай гэрчилгээний хавсралтаар гэрчилгээжсэн.

"Алтай", "Дэглий цагаан", "Ховд" "Өлгий" "Гурвансайхан", "Отгонтэнгэр" "Чойбалсан", "Мөрөн", нисэх буудалтай хамтарч газрын үйлчилгээний үйл ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, нисэх буудлын даргаар нь 2022 оны 01 дүгээр сарын 31, 2022 оны 03 дугаар сарын 22, 2022 оны 04 дүгээр сарын 24, 2022 оны 06 дугаар сарын 22, 2022 оны 09 дүгээр сарын 29, 2022 оны 09 дүгээр сарын 28, 2022 оны 10 дугаар сарын 31, 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд тус тус батлуулсан.

Орон нутгийн нисэх буудлуудын газрын үйлчилгээний тарифыг шинэчлэн батлуулахтай холбогдуулан орон нутгийн нисэх буудлын газрын үйл ажиллагааны зураглалыг гаргасан.

#### **"Буянт-ухаа" Олон улсын нисэх буудлын талаар:**



Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/138 дугаар тушаалаар “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдаж, 99 орон тоотойгоор нисэх буудлын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.

Тус нисэх буудал нь Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид ИНЕГ гэх), Иргэний нисэхийн үндэсний төв (цаашид ИНҮТ гэх), болон Нисэх буудлуудын үйлчилгээний газрын (цаашид НБҮГ гэх), 7 хоногийн үйлдвэрлэлийн шуурхай зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтийг ханган заасан хугацаанд биелэлтийг хүргүүлэн ажилласан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал нь 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө шинэчлэн 2022 оны 07 дугаар сарын 27-ны өдөр ИНҮТ-ийн даргаар батлуулж, тус төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган 2022 оны 03 дугаар улирлын байдлаар 98,5% биелэлттэй байна. Тайлант хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

“Нисэх миний ирээдүй” өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгт 300 гаруй хүнд нисэх буудлын үйл ажиллагааг сурталчилсан.

#### *Эрсдэлийн үнэлгээ:*

ИНЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалаар байгуулагдсан БУОУНБ-д аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, хориотой, хамгаалагдсан, нийтийн эзэмшлийн бүс болон хилийн хяналт, шалгалтын бүсийг шинэчлэн тогтоох ажлын хэсэг тус нисэх буудалд ажиллахтай холбоотой бэлтгэл ажлыг ханган, ажлын хэсэгтэй хамтран ажилласан. Тус ажлын хэсгийн эрсдэлийн үнэлгээний тайлангийн дагуу гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдөр ИНҮТ-ийн даргаар батлуулан НБҮГ-т хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

“Буянт-Ухаа” ОУНБ-ын олон улсын нисэх буудлаар ашиглан олон улсын зорчигч тээврийн нислэг хүлээн авахад бэлэн байдлыг хангах үеийн эрсдэлийн судалгаа, үнэлгээ”-ний эрсдэлийн баг ажиллаж, 2022 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр тайланг нэгтгэн гаргасан.

#### *Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх ажлын хүрээнд:*

Нисэх буудлын даргын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/22 тоот тушаалаар нисэх буудлын аюулгүй ажиллагааны гүйцэтгэлийг шаардлагын түвшинд хүргэхийн тулд аюулгүй ажиллагаа хариуцсан албан тушаалтанд зөвлөх, нисэх буудалд аюулгүй ажиллагаатай холбоотой тулгамдсан асуудлыг хамтын зарчмаар хэлэлцэж шийдвэр гаргах зорилготой нисэх буудлын “Аюулгүй ажиллагааны хороо”-г байгуулсан. Нисэх буудлын аюулгүй ажиллагааны хорооны хурлыг 2022 оны 03 дугаар сарын 31, 07 дугаар сарын 01, 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд зохион байгуулж, хурлын шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ААУТ-г хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан биелэлтийг нэгтгэн ажилласан. Тус төлөвлөгөөнд нийт 9 ажил төлөвлөж, 100% хэрэгжүүлсэн байна. АА-ны хорооны нэгдүгээр хурлаас 5, хоёрдугаар хурлаас 6, гуравдугаар хурлаас 3 шийдвэр гарсан бөгөөд хэрэгжилт 100%, дөрөвдүгээр хурлаас гарсан 4 шийдвэрийн хэрэгжилт 82%-тай байна.

#### *Үл тохирлын бүртгэл, хяналт*

Тайлант хугацаанд тус нисэх буудлын үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагаанд нийт 40 үл тохирол илэрсэн. Эдгээр илэрсэн үл тохирлуудад тайлант өдрөөр дүн шинжилгээ хийхэд:

- Аюулгүй ажиллагаатай холбоотой 15 (37.5%);
- Аюулгүй байдалтай холбоотой 6 (15%);
- ХАБЭА-тай холбоотой 19 (47.5%) байна.

Түүнчлэн нийт үл тохирлыг хүчин зүйлээр ангилж үзэхэд хүний хүчин зүйлээс шалтгаалсан 15 (37.5%), техникийн хүчин зүйлээс шалтгаалсан 11 (27.5%), байгалийн хүчин зүйлээс шалтгаалсан 14 (35%) байна. Мөн нийт үл тохирлын 32.5% хувь буюу 13 нь нисэх буудлын нэгжүүдийн үйл ажиллагаатай, 67.5% буюу 27 үл тохирол нисэх буудалд үйл ажиллагаа явуулж буй ИНҮТ-ийн алба, салбар болон түрээслэгч байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотойгоор илэрсэн байна.

#### *Аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх чиглэлээр:*

Монгол Улсын Засгийн газрын 455 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, ИНД-139 “Аэродромын үйл ажиллагаа, гэрчилгээжүүлэлт” дүрмийн дагуу “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал хязгаарлагдмал аэродромын гэрчилгээ эзэмшсэнтэй холбогдуулан “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын “Аюулгүй байдлын хөтөлбөр”-ийг ИНЕГ-ын 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн А/82 дугаар тушаалаар батлуулсан.

“Буянт-Ухаа” ОУНБ-ын Аюулгүй байдлын хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт бус үзлэг шалгалтын удирдамжийг боловсруулан, батлуулж үзлэг, шалгалтыг 2022 оны 08 дугаар сарын 01-ээс 05-ны өдрүүдэд зохион байгуулж, тайланг нэгтгэж зөвлөмжийг холбогдох албуудад хүргүүлэн ажилласан.

#### *Нислэг үйлдвэрлэлийн чиглэлээр*

Тайлант хугацаанд (2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар) “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд олон улсын 42, орон нутгийн 1702





нийт 1748 нислэг үйлдэгдэж, 2458 зорчигч тээвэрлэж, нислэгийн зохицуулалтыг хийж, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажилласан.

Тайлангийн хугацаанд “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлыг 1872 удаа нөөц нисэх буудлаар сонгосон хүсэлт хүлээн авсан. Аэродром дээрх үйл ажиллагаатай холбоотой 84 NOTAM мэдээ зарлуулсан. Аэродромын бэлэн байдлыг хангах үзлэг шалгалтыг нийт 1772 удаа хийж, AFTN мэдээг 380 удаа дамжуулж, олон улсын нислэгийн агаарын хөлгийн зогсоолыг 42, орон нутгийн агаарын хөлгийн зогсоолыг 405 удаа хуваарилж ажилласан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын “Аюулгүй ажиллагааны хороо”-ны 01 дүгээр хурлыг 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, 2 дугаар хурлыг 06 дугаар сарын 30-ны өдөр тус тус зохион байгуулж, шийдвэрийг гаргуулан батлуулж, хэрэгжилтийг 100 хувь хангуулан ажилласан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Аюулгүй байдлын хорооны 2022 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, хорооны 01 дүгээр хурлын төлөвлөгөөг боловсруулж “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дарга бөгөөд Аюулгүй байдлын хорооны даргаар 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдөр батлуулсан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Аюулгүй байдлын хорооны хурлыг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Уг хуралд хорооны гишүүн 21 байгууллагын 30 ажилтан, албан хаагч оролцсон.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын 2022 оны “Онцгой нөхцөлийн төлөвлөгөө”-ний дасгал сургуулилтын төлөвлөгөөг боловсруулан “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын даргаар 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр батлуулсан.

“Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний КОД-3” буюу Онцгой байдлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлэн байдлыг шаардах нислэг техникийн осол, зөрчил”-ийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ сэдэвт хэсэгчилсэн дасгал сургуулалтыг 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Уг дасгал сургуулилтад НБУГ-ын удирдлага, нисэх буудлын удирдлага, АБХА, ИАТЦХ, НЭМСЗА-ны эмч, нисэх буудлын нэгжүүдийн ажилтнууд нийт 32 ажилтан оролцсон. Дасгал сургуулилтаас гарсан зөвлөмжийн дагуу бататгах зорилгоор “Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний КОД-3” буюу Онцгой байдлын үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны бэлэн байдлыг шаардах нислэг техникийн осол, зөрчил”-ийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ сэдэвт ширээний дасгал сургуулилтыг 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан. Уг дасгал сургуулилтад нисэх буудлын удирдлага, бүтцийн нэгжүүд болон АБХА-наас нийт 18 ажилтан оролцсон.

“Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний КОД-1” буюу “Нисэх буудалд тохиолдсон агаарын хөлгийн осол, зөрчил”-ийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ сэдэвт танхимын дасгал сургуулилтыг 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Уг дасгал сургуулилтад нисэх буудлын удирдлага, бүтцийн нэгжүүд, НМУА-ны ерөнхий нислэгийн хөдөлгөөний удирдагч зэрэг нийт 25 ажилтан ажилтан оролцсон.

Онцгой нөхцөлийн төлөвлөгөөний КОД 4 буюу “Барилга байгууламжид гарсан гал түймрийн үед авч хэрэгжүүлэх ажиллагаа” сэдэвт танхимын дасгал сургуулилтын зохиомжийг боловсруулан уг дасгал сургуулилтыг Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтсийн харьяа Гал унтраах, аврах 30 дугаар ангитай хамтран 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

Ковид-19 цар тахлын үед ажиллах “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйлдвэрлэлийн нэгжүүдийн нөөц төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, ИНҮТ-ийн даргаар 2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр батлуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 455 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд “Буянт-Ухаа” олон улсын нисэх буудлыг нөөц нисэх буудлаар ашиглах үед нислэг үйлдвэрлэлийн тасралтгүй бэлэн байдлыг хангах, холбогдох байгууллага нэгжүүдийн авч хэрэгжүүлэх хүн хүч, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг шалгах, хамтын ажиллагааны нэгдмэл байдал, ажлын уялдаа холбоог сайжруулах, цаашид авч хэрэгжүүлэх ажиллагаануудыг тодорхойлох зорилгоор “Түргэн цугларалт”-ын удирдамж боловсруулан “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын дарга болон Хилийн 0218 дугаар ангийн захирагчаар батлуулан, 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдөр амжилттай зохион байгуулсан. “Буянт-Ухаа” ОУНБ-ыг нөөц нисэх буудлаар ашиглан олон улсын 145 зорчигчтой Boeing 737-800 агаарын хөлөг, 240 зорчигчтой А330-300, 50 зорчигчтой Fokker 50 агаарын хөлгүүд 2022 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 07:00, 07:10, 07:20 цагт тус тус буух гэж байгаа тухай НӨХЦӨЛ байдлыг сценари болгосон. Уг цугларалтад нийт 13 байгууллагын 92 ажилтан, 27 тоног төхөөрөмж, машин механизм, техник оролцсон.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын аэродромд 2022 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр болон дадлага хийж байсан Cessna 172S, MIG-29 хөлгүүдэд тохиолдсон зөрчлийн талаарх мэдээллийг ИНД-12.55-ын дагуу СА005 маягыг бөглөн 21 хуудас хавсралтын хамт 10-28/46 тоот албан бичгээр 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанд хүргүүлсэн.

2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/112 дугаар “Үйлчилгээний хураамж батлах тухай” тушаалын дагуу нисэх буудлын шинэчлэгдсэн үйлчилгээний хураамжийн мэдээллийг Нисэхийн



мэдээллийн үйлчилгээний байгууллагад 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр АИР-д зарлуулахаар хүргүүлсэн.

ИНЕГ-ын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албанаас 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 03/6/176 тоот албан бичгээр ирүүлсэн байцаагчийн 93/22 тоот дүгнэлтийн дагуу “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын “Аюулгүй байдлын хөтөлбөр”-ийг холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлэн дахин боловсруулж 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр ИНЕГ-ын даргаар батлуулсан. Хорооны гишүүд болон холбогдох байгууллагуудад хөтөлбөрийг тараалтыг цаасаар болон цахимаар хүргүүлсэн.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын Нисэхийн мэдээллийн эмхэтгэлд зарлуулах ИНҮТ-ийн даргын 2022 оны 01 дүгээр 22-ний өдрийн “Үйлчилгээний хураамж батлах тухай” А/11 тоот тушаалын дагуу аэродромын үйлчилгээний тарифын мэдээлэлд оруулах өөрчлөлтийн тодруулгыг Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанд 2022 оны 02 дугаар сарын 28-ний өдөр цахимаар хүргүүлсэн.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд олон улсын нислэг хүлээн авах үеийн үйл явдлын зохиомжийг 3 хэлбэрээр /зорчигчтой, зорчигчгүй-карго, гурван нислэг давхардсан/ боловсруулан, удирдлагад танилцуулан, зохиомжийн дагуу агаарын хөлгийг зогсоолд байрлуулах болон зорчигчдыг хүлээн авах урсгал төлөвлөлтийг боловсруулж 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр батлуулсан.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын аэродромын “Ерөнхий заавар”-ын 1, 2, 3 дугаар бүлгүүдэд нэмэлт өөрчлөлтийг оруулан НААХЗА-аар хянуулан, хүлээн зөвшөөрүүлэхээр 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 10-15/356 тоот албан бичгээр ИНЕГ-ийн даргад хүргүүлсэн.

Зуны хугацаанд нислэгийн эрчимжилтийг нэмэгдүүлэхээр үйл ажиллагаа явуулах хугацааг гэрэлтэй цагтай уялдуулан зохион байгуулж үйл ажиллагаа явуулах хугацааг 05 дугаар сарын 04-ний өдрөөс 09 дүгээр сарын 03-ны өдрийн хооронд 05:00-21:00 хүртэл, 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 04-ний өдрийн хооронд 07:30-19:30 хүртэл тогтоон холбогдох зохицуулалтыг хийж НОТАМ мэдээ зарлуулсан.

Монгол Улсад нисэх хүчин үүсэж хөгжсөний 97 жилийн ойн арга хэмжээний хүрээнд “Буянт-Ухаа” ОУНБ-ын ашиглалтыг сайжруулахад Аялал жуулчлалын байгууллага, агаарын тээвэрлэгчдийн оролцоо сэдэвт форумыг 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Тус форумд ЗТХЯ, ИНЕГ, ИНҮТ, НБҮГ, болон агаарын тээвэрлэгч байгууллагууд аялал жуулчлалын тур операторууд оролцож санал солилцсон. Форумгаас гарсан саналыг нэгтгэн ИНЕГ-т 2022 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 10-15/319 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Ерөнхий зааврын 3 дугаар бүлгийн “Код 4-Барилга байгууламжид гарсан гал түймэр”-т бэлэн байдлыг хангах, нийт ажилтнуудын галын аюулгүй байдлын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор ХУД-ийн аврах гал унтраах 30 дугаар ангитай хамтран “Байгууллагын галын аюулгүй байдал” сэдэвт сургалтыг 2022 оны 8 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Дасгал сургуулилтад нийт 30 ажилтан албан хаагчид оролцсон. Уг дасгал сургуулилтаар хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах мөн тулгамдсан асуудлуудыг шүүн ярилцсан ба санал зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нисэх буудлын даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажилласан.

“Буянт-Ухаа” ОУНБ-ыг Олон улсын нислэгт нөөцөөр авсан үед перрон талбай болон зорчигчийн урсгалыг хэрхэн зохицуулах, 3 агаарын хөлөг зэрэг буусан, ачааны агаарын хөлөг буусан үед болон олон улсын том оврын агаарын хөлгийг перрон талбайд авсан үед зорчигчийн бөөгнөрлийг хэрхэн зохицуулах талаар судалгаа хийж зохиомж боловсруулсан.

Тус нисэх буудал нь агаарын тээвэрлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг технологийн дагуу үзүүлэх, нисэх буудлын барилга байгууламж, перрон талбайг агаарын тээвэрлэгчид ашиглуулах, агаарын тээвэрлэгч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг авах болон үйлчилгээний хураамж, ашиглалтын төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулах үүднээс агаарын тээвэрлэгч 13 байгууллагуудтай “Үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г шинэчлэн байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг дүгнэн ажилласан.

“Буянт-Ухаа” ОУНБ-ын Аюулгүй байдлын хорооны 2022 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, хорооны 01 дүгээр хурлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан Аюулгүй байдлын хорооны хурлыг 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Уг хуралд хорооны гишүүн 21 байгууллагын 30 ажилтан, албан хаагч оролцсон. Тус хурлын шийдвэрийн дагуу “Буянт-Ухаа” ОУНБ, агаарын тээвэрлэгч, хилийн хяналтын байгууллагууд болон ИНҮТ-ийн албадтай хамтран өргөтгөсөн түргэн цугларалтыг хийсэн. Тус түргэн цугларалтын хүрээнд гарч болох эрсдэлийг тооцоолон эрсдэлийн үнэлгээг хийж тайланг боловсруулан үйлдвэрлэлийн нэгжүүдэд хүргүүлсэн.

“Буянт-Ухаа” ОУНБ-ын даргын 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/51 дугаар тушаалаар “Буянт-Ухаа” ОУНБ-ын аэродромын гэрчилгээг ИНД-139-ийн хүрээнд сунгуулах бэлтгэл ажлыг хангах, өргөдөл гаргах ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын ИНД139-ийн дагуу гэрчилгээжих хүсэлт болон “Ерөнхий зааврыг шинэчлэн



боловсруулж, хянуулан хүлээн зөвшөөрүүлэхээр 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 10-15/580 тоот албан бичгээр НААХЗА-д хүргүүлсэн.

“Буянт-Ухаа” ОУНБ-ын үр өгөөжийг сайжруулахад гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, тэдгээрийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах мэдээлэл, судалгаа боловсруулж танилцуулгыг монгол, англи дээр бэлтгэн ИНЕГ-ын даргад 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр танилцуулсан.

Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын албанаас 2022 оны 06 дугаар сарын 29-нөөс 07 дугаар сарын 01-ны өдрүүдэд нислэг үйлдвэрлэлийн бэлэн байдлыг шалгах төлөвлөгөөт бус үзлэг шалгалт хийсэн. Тус үзлэг шалгалтын зөвлөмжийн дагуу ажлын төлөвлөгөөг боловсруулан ИНҮТ-д 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 10-15/433 тоот албан бичгээр хүргүүлсэн. Тус төлөвлөгөөний биелэлт 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар 95%-ийн гүйцэтгэлтэй байна.

#### **Газрын үйлчилгээ, шатахуун хангалтын чиглэлээр:**

“Агаарын хөлгийг шатах тослох материалаар хангах үйлчилгээний байгууллагын гэрчилгээ” № МСАА.144.008/20 тоот гэрчилгээг 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийг хүртэл сунгуулсан.

Тус алба 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр ISO9001:2016 стандарт нэвтрүүлсэн байгууллага болсныг батламжлах гэрчилгээг 3 жилээр сунгуулж, Менежментийн тогтолцооны гэрчилгээ, стандартын тэмдэглэгээ хэрэглэх тухай гэрээг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Стандарт хэмжил зүйн газартай хийсэн.

Албаны удирдлагын баримт бичгийг шинэчлэн боловсруулж, 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Технологи, газрын үйлчилгээний хэсгийн үйл ажиллагааны зааврыг НБҮГ-аар хянуулан 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр тус тус ИНҮТ-ийн даргаар батлуулсан.

#### **Агаарын хөлгийн газрын үйлчилгээ**

2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр нийт 3931 агаарын хөлөг /орон нутаг-1608, олон улс-2323/-т нийт 24 нэгж газрын техник, тоног төхөөрөмжөөр давхардсан тоогоор 26660 удаагийн үйлчилгээ үзүүлж, 99102 км гүйж, нийт 18484,40 мото/цагийн газрын техник, тоног төхөөрөмжийн үйлчилгээг үзүүлсэн.

2021 оны мөн үеийнхтэй харьцуулвал, үйлчилсэн агаарын хөлгийн тоо 1.8 дахин, үйлчилгээ үзүүлсэн газрын техник, тоног төхөөрөмжүүдийн тоо 2.0 дахин, гүйлт 2.17 дахин, үйлчилгээ үзүүлсэн хугацаа 1.66 дахин тус тус өссөн байна. Энэ өсөлт нь дэлхий даяар агаарын тээвэр сэргэж, Монгол улс хилээ нээсэнтэй холбоотой.

Тайлант хугацаанд “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал дээр нийт 9 нэгж газрын техник, тоног төхөөрөмжөөр 380 агаарын хөлөгт, давхардсан тоогоор 443 удаа үйлчилгээ үзүүлж, 1776 км, 78.25 мото/цагийн газрын үйлчилгээ үзүүлсэн байна.

Агаарын хөлгийн газрын үйлчилгээнд онгоц үйлчилгээний нийт 35 ажилтан 24 газрын техник, тоног төхөөрөмж ажиллаж байна. Хөдлөх бүрэлдэхүүний парк ашиглалт 53,6 хувь, техникийн бэлэн байдлын коэффициент 0.97 байна.

“Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын аэродромын хэсэгт нийт 5 ажилтан, 11 нэгж машин, механизмаар 8400 км, 2595 мото/цагийн үйлчилгээ үзүүлсэн. 2021 оны мөн үетэй харьцуулахад, гүйлт 1.76 дахин, үйлчилгээ үзүүлсэн цаг 4.9 дахин буурсан байна. Энэхүү бууралт нь 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр “Чингис хаан” Олон улсын нисэх буудал ашиглалтад орсонтой холбоотой байна.

“НУБИЭ” ХХК-ийн Газрын үйлчилгээний газрын холбогдох ажилтнуудтай уулзалт хийж “Хамтын ажиллагааны гэрээ”-ний биелэлтийг дүгнэсэн.

“МИАТ” ТӨХК-тай 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр “Тоног төхөөрөмжийн түрээсийн гэрээ”-г 1 жилийн хугацаатай байгуулан ажиллаж байна.

#### **Нийтийн болон технологийн тээврийн үйлчилгээ:**

2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 15896 машин/өдөрт, 194385 цагийн ажил гүйцэтгэж, 2,6 сая километрийн үйлчилгээ үзүүлсэн байна. 2021 оны мөн үеийнхтэй харьцуулвал нийтийн тээврийн машин/өдөр 7,8%-иар, үйлчилгээний цаг 13,4%-иар, явсан километр 7,0%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Энэхүү бууралт нь төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан зарим технологийн үйлчилгээг түр зогсоож, нэгтгэсэнтэй холбоотой байна.

Нийтийн тээвэрт 70 автомашинтайгаас 60-62 автомашин тогтмол ажилд гарч, парк ашиглалт нь 58.4%, техникийн бэлэн байдлын коэффициент 0,96 байна. 2021 оны мөн үеийнхтэй харьцуулвал парк ашиглалт 10,7%-иар буурсан боловч нэг жолоочийн дундаж гүйлт 38032 км явсан нь өмнөх онтой харьцуулахад 4.3%-иар өссөн байна.

Хуваарьт, лимитээс гадна харилцагч байгууллагуудын захиалгаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр ИНЕГ болон ИНҮТ түүний харьяа алба, нэгжүүдээс ирсэн 391 захиалга хуудсаар 1505 машин/өдөр, 11729 цаг, 287034 километрийн нэмэлт захиалгын үйлчилгээг сааталгүй үзүүлсэн.

Хэмнэлтийн горимтой холбогдуулан ИНЕГ-ын дарга, дэд дарга, НБҮГ-ын дарга нарт нэгтгэх боломжид лимит, шатахууны зардал, чиглэлийн талаарх судалгаа гаргаж танилцуулан, ИНЕГ-ын



даргын үйлдвэрлэлийн шуурхай хурлаас өгсөн чиглэлийн дагуу 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Агаарын навигаци, үйлчилгээний газрын албадын дарга нартай уулзалт зохион байгуулан, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал дахь ХНАА, НХҮА, НМҮА-ны ээлжийн ажилтнуудад үйлчилж байсан 3 унааг 2 болгож нэгтгэж, “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудал дахь ХНАА-ны ээлжийн ажилтнуудад үйлчилдэг Коунти маркийн автобусанд НУТА-ны ажилтнуудыг нэгтгэн явуулж арга хэмжээг зохион байгуулан, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Замын хөдөлгөөний төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газарт хандаж Иргэний нисэхийн зайлшгүй ажлын шаардлагаар зорчиж буй 3 автомашинд улсын дугаарын хязгаарлалтад үл хамаарах эрхийг авсан.

Ажилчдын автобусны автозамын 1 дүгээр эгнээ болон улсын дугаарын хязгаарлалт үл хамаарахын эрхийн 2022 оны 1 болон 2 дахь шатны үзлэг оношлогоонд Нийслэлийн тээврийн газрын оношлогооны газарт 18 тээврийн хэрэгслийг амжилттай хамруулан 2023 оны 03 дугаар сар хүртэл эрхийг авсан.

2022 оны автотээврийн техникийн улсын үзлэгт нийтийн тээврийн 70, шатахуун тээврийн 5 автомашиныг амжилттай хамруулж техникийн бэлэн байдлыг хангасан.

#### Шатахуун хангалтын үйлчилгээ

2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4124 тонн агаарын хөлгийн шатахууныг орон нутгийн 11 аймгийн нисэх буудлын шатахууны агуулахад захиалгын дагуу тээвэрлэж, нийт 164,9 мян/км, 554 машин/өдөр, 1.266.324 т/км-ын ажил хийж гүйцэтгэсэн нь 2021 оны мөн үеийнхтэй харьцуулбал тээвэрлэсэн агаарын хөлгийн шатахуун 74,2%-иар, ачаа эргэлт 55,7%-иар, явсан гүйлт 61,7%-иар, ажилласан машин/өдөр 59,2%-иар тус тус өссөн байна.

2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр “Эрчис Ойл” ХХК-тай байгуулсан 22/26 дугаартай гэрээний дагуу Магнай трэйд” ХХК-ийн агуулахаас “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын Шатахуун хангамжийн байгууламжийн агуулахад 6,500,000 литр буюу 5,330 тн шатахууныг тээвэрлэсэн.

2022 оны гуравдугаар улирлын байдлаар төвийн ШТС-ын шатахууны нөөцөд хяналт тавьж Аи-92 автобензин 181400, Дизель түлш 565640, евро-5 дизель түлш 78120 литрийг гэрээт “НИК” ХХК болон “Шунхлай трейдинг” ХХК-иас тус тус татан авч нөөц бүрдүүлсэн. 2022 онд багтаан нэмэлт гэрээг байгуулах үнэлгээний хороо байгуулан 1,1 тэрбум төгрөгийн төсөвтэй тендер зарласан.

2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар Орон нутгийн нисэх буудлуудын ТС-1 шатахууны нийт нөөц 520,6 тонн, үүнээс ИНЕГ-ын нөөц 289,90 тонн байна.

Аи-92=10250л, ДТ=27031л, ТС1=1415л, Евро-ДТ=0 нөөцтэй байна.

Мөстлөгийн эсрэг шингэний нөөц: De-/anti-icing Type-IV=12762 De/icing Type I=0, нийт 12762 л нөөцтэй.

Тайлант хугацаанд шатахууны агуулах, шатахуун цэнэглэгч автомашины тоолуур, торх хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хийлгэж, орон нутгийн шатахууны агуулахын засвар үйлчилгээг төлөвлөгөөний дагуу төвийн ШТС-ын 4 түгээгүүр, 5 автоцистерны 25 торх, орон нутгийн 6 аймгийн секундометрийг Стандарт, хэмжилзүйн газраар баталгаажуулж дууссан.

2022 оны 8 дугаар сар, 10 дугаар саруудад 9 аймгийн нисэх буудлын шатахууны агуулахуудад засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан 6 аймгийн шатахууны агуулахын цэвэрлэгээг хийх ажил тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон. Нийт 40 ширхэг сав цэвэрлэхээс 32 цэвэрлэж гүйцэтгэл 80%, 1525м3 сав цэвэрлэхээс 1275м3 сав цэвэрлэж гүйцэтгэл 83,6%-тай байна.

ИНЕГ-ын даргын 2022 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн өргөтгөсөн шуурхайгаас өгөгдсөн үүргийн дагуу Хөвсгөл аймаг 5ш(50м3\*2ш, 25м3\*3ш), Булган аймаг 2ш(50м3\*2ш), Тосонцэнгэл 2ш(50м3\*2ш), Баян-өлгий 2ш(75м3\*2ш) нийт 11 савыг консервацид тавьсан.

Орон нутгийн нисэх буудлуудын шатахууны агуулах, сумалгаа хийх үйл ажиллагааг ИНД-144 S3 ангиллаар гэрчилгээжүүлэх ажлын хүрээнд Өвөрхангай, Тосонцэнгэл аймгийн нисэх буудлуудыг ИНД-144 S-3 ангиллаар гэрчилгээжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хууулийн 13.1.4 дэх заалт, Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны А/93 тушаалын 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Сүхбаатар аймгийн нисэх буудлын гэрчилгээжүүлэлтийн ажил түр хойшлогдсон.

Орон нутагт тээвэрлэх агаарын хөлгийн ТС-1 шатахууны дээжийг 60 удаа, төвийн шатахуун түгээх станцын шатахуунаас хяналтын шинжилгээний дээж 3 удаа, мөстөлтийн эсрэг шингэний дээж 6 удаа, орон нутгийн нисэх буудлуудын шатахууны агуулахуудаас улирлын хяналтын дээж 15 удаа тус тус авч Оношилгоо хэмжил зүйн лабораторид шинжлүүлэн, чанарт хяналт тавьж ажилласан. Зам тээврийн хөгжлийн яамны харьяа Зам тээврийн хөгжлийн төвтэй уулзалт хийж “Эрчис Ойл” ХХК-ийн шатахуун тээвэрлэлтийг шуурхайлах, төсөв хэмнэх үүднээс “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын шалган бүртгэх товчоогоор ирэх оны 5 сарын дуустал үнэ төлбөргүй нэвтрүүлэх тохиролцоонд хүрч гэрээ байгуулахаар бэлтгэл хангаж байна.



### **ТАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Захиргаа, удирдлагын газар нь Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, байгууллагын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй, шуурхай байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Тус байгууллагын дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, тушаалын хэрэгжилтийг хангах, биелэлтийг нэгтгэх Зам, тээврийн хөгжлийн яам, холбогдох байгууллагуудад тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Мөн хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хийх, гадаад орнуудын тэтгэлэгт хөтөлбөрт ажилтнуудыг хамруулахад дэмжлэг үзүүлэх, ажилтнуудын чадавхийг дээшлүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм журам зааврыг дагаж мөрдүүлэх, ажилтнуудын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, ажлын байрны өрөө тасалгааны хуваарилалт, тохижилт, цэвэрлэгээ, харуул хамгаалалтанд хяналт тавих, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах, байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, стандарт, журмын дагуу тасралтгүй хөтлөн явуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### **Эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр:**

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр дараах эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ;
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн “Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/29 дүгээр тушаалаар Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрэмд өөрчлөлт оруулан батлуулж, холбогдох газруудад хүргүүлсэн.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/270 дугаар тушаалаар батлуулсан.
- “Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн боловсруулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/230 дугаар тушаалаар батлуулсан.

Сургалтын асуудал хариуцсан байнгын зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай журмыг шинэчлэн боловсруулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/255 дугаар тушаалаар батлуулсан.

#### **Захиргааны үйл ажиллагаа:**

Удирдах дээд байгууллагын тогтоол, албан даалгавар, тушаал, шийдвэрийн хүрээнд 400 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг гарган холбогдох нэгж, байгууллагад хүргүүлсэн. Үүнд:

- Ерөнхийлөгчийн зарлиг -1
- Ерөнхий сайдын захирамж -4
- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл -19
- Засгийн газрын тогтоол -17
- Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал -4
- Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөлийн хуралдааны тэмдэглэл -2
- Удирдах ажилтны зөвлөгөөний зөвлөмжийн хэрэгжилт - 5
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаал - 348

Монгол улсын Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл, тогтоолыг бүртгэн авч, Даргын зөвлөлийн гишүүдэд танилцуулж, холбогдох газруудад ИНЕГ-ын даргын цохолтын дагуу цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлж байна.

Удирдах дээд газруудаас өгсөн үүрэг даалгавар, тушаал, шийдвэрийн биелэлтийн байдал:

- Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлт болон удаашралтай үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж, тухай бүрд тус яаманд хүргүүлэн тайлагнасан.



- Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны “Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хангалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгавар, 2021 оны “Цахимжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай” 07 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг сар бүр гарган, Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлж тайлагнасан бөгөөд албан даалгавруудын биелэлт 100%-тай дүгнэгдсэн.
- “Агаарын тээврийн либералчлал, иргэний нисэхийн салбарын шинэчлэл” удирдах ажилтны зөвлөгөөний зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гарган Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн. Биелэлт 89.2%-тэй байна.
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, “Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам”-ын хэрэгжилтийг сар бүрийн 30-ны өдрийн байдлаар гаргаж, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газарт албан бичгээр хүргүүлж байна.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын “Сахилга, хариуцлагыг өндөржүүлэх тухай” 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 01 тоот албан даалгаврын хэрэгжилтийг сар бүрийн 30-ны өдрийн байдлаар гарган Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад танилцуулсан.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын баталсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын төсвийн хэмнэлт, нэмэлт орлого олох төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийг сар бүрийн 30-ны өдрийн байдлаар гарган Дотоод аудитын албанд хүргүүлж, удирдлагад танилцуулсан.
- Санхүүгийн аудит шалгалтаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтэд Захиргаа, удирдлагын газрын хариуцах арга хэмжээний биелэлтийг улирал бүр гарган Санхүү, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын баталсан тушаалын биелэлтийг сар бүр гаргаж, Дотоод аудитын албанд хүргүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд 348 А тушаал, 304 Б тушаал гарч, тушаалын биелэлтүүдэд хяналт тавьж ажиллаа.
- Шилэн дансанд Иргэний нисэхийн ерөнхий газрын орон тооны мэдээг сар бүрийн 05-ны өдрийн дотор шивж оруулан хуулийн хэрэгжилтийг хангасан.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд Захиргаа, удирдлагын газраас тусгах саналыг боловсруулан Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газарт 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 2081 тоот албан бичгээр хүргүүлсэн.
- Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн №28 дугаар хурлын тэмдэглэл, “Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах” үүрэг өгөгдсний дагуу Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжүүдийн ажилтнуудыг тоон гарын үсэгтэй болгох ажлыг Чингэлтэй дүүргийн Бүртгэлийн хэлтэстэй хамтран 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, 199 ажилтан тоон гарын үсэгтэй болсон.
- Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогттой 2022 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр хийсэн уулзалтын тэмдэглэлийг хөтөлж, үүрэг даалгаврыг харьяалуулж Зам, тээврийн хөгжлийн яаманд цахим шуудангаар хүргүүлсэн.
- Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн 09/1941 тоот албан бичгийн дагуу Улсын байцаагчийн томилох тухай шийдвэрийн төсөл, албан тушаалын тодорхойлолтын төсөл, холбогдох танилцуулгыг боловсруулж, 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 01/771 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

#### **Хүний нөөцийн сургалт, мэдээллийн чиглэлээр:**

##### Сургалтын талаар:

Гадны байгууллагаас ирүүлсэн саналын дагуу ажилтнуудыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулан, ажилтнуудын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Удирдлагын академиас зохион байгуулсан сургалтуудад ажилтнуудыг хамруулсан байдал:

- 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөдөлмөр харилцааны зохицуулалтын шинэчлэл” сэдэвт цахим сургалтад Захиргаа, удирдлагын газрын 2 мэргэжилтэн хамрагдаж, гэрчилгээжсэн.



- 2022 оны 09 дүгээр сараас 12 дугаар сар хүртэл хугацаанд зохион байгуулагдаж буй төрийн албан хаагчийн багц сургалтад Иргэний нисэхийн ерөнхий газрын 4 ажилтныг хамруулах ажлыг зохион байгуулж, холбогдох тушаалыг боловсруулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар батлуулсан. Тус сургалтад хамрагдаж буй 4 ажилтантай “Удирдлагын академид улсын төсвийн санхүүжилтээр суралцах төрийн албан хаагчтай байгуулах гурван талт гэрээ”-г байгуулан, ИНЕГ-ын даргаар батлуулж, хувийг холбогдох газруудад хүргүүлсэн.
- Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого сургалтад Иргэний нисэхийн ерөнхий газар, Иргэний нисэхийн үндэсний төвийн нийт 20 ажилтныг хамруулсан.
- Улсын төсвийн санхүүжилтээр суралцах төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны 4 төрлийн сургалтад 11 ажилтныг хамруулсан.

Архивын ерөнхий газраас 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй” сэдэвт сургалтад албан хэрэг хөтлөлт хариуцсан 1 мэргэжилтнийг хамруулсан.

Төрийн албаны зөвлөлөөс Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих зорилгоор 7 хоног бүрийн пүрэв гаригт зохион байгуулж буй цахим сургалтад Захиргаа, удирдлагын газрын ажилтнууд тогтмол хамрагдаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газарт мэдээллийн цаг арга хэмжээг “Бүтээмж чанарын тууш удирдлага”, “Бүтээмж ба байгууллагын соёл”, “Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо-ISO9001:2015”, “Процессын хандлага” сэдвүүдээр “Тотал Куалити Девелопмент Консалтинг” ХХК-ийн үүсгэн байгуулагч, Монголын мэргэшсэн менежментийн зөвлөх багш Б.Уранчимэгтэй хамтран зохион байгуулж, давхардсан тоогоор танхимаар 57, цахимаар 70 нийт 127 ажилтныг хамруулж байгууллагын соёл, тогтвортой хөгжил, бүтээмж-чанарын уялдаа холбоо, олон улсын чанарын удирдлагын менежмент, ач холбогдол, процессын хандлага ажлын бүтээмжид хэрхэн нөлөөлдөг талаарх анхан шатны мэдлэг, мэдээлэлтэй танилцуулсан.

Ерөнхийлөгчийн ивээл дор 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулагдсан Хүүхдэд ээлтэй Монгол үндэсний чуулган, “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үндэсний зөвлөгөө”-нд ИНЕГ-ын дэргэдэх эцэг, эхийн зөвлөлийн 5 гишүүнийг оролцуулсан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны анхдугаар чуулганд архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан 1 ажилтныг оролцуулсан.

Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнуудын үндэсний бичгийн түвшин тогтоох шалгалтыг мэргэжлийн багштай хамтран 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, 88 ажилтныг хамруулан, сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлов. Ажилтнуудын 87.5% нь анхан шатны, 9% нь дунд шатны, 3.4% нь ахисан түвшний мэдлэгтэй байгааг тодорхойлсон.

#### **Сургалтын хөтөлбөр боловсруулалтын үйл ажиллагаа:**

Нисэхийн сургалтын төв нь 2021 жилийн эцсийн байдлаар хөтөлбөрийн сэдвийн агуулгыг багтаасан нийт 137 хөтөлбөрийг сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байсан. 2022 онд сургалтын чанарыг сайжруулах, суралцагчдын оролцоог түлхүү болгох, ажлын байранд ажилчдын ур чадвар, хандлагыг дээшлүүлэх зорилгоор “НСТ-ийн дотоод сургалтын хөтөлбөрүүдийг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт шилжүүлэн боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулан 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НСТ-ийн захирлаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу төлөвлөгөөт 14, төлөвлөгөөт бус 7 сургалтын хөтөлбөрийг батлуулж сургалтын үйл ажиллагаанд ашиглаж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр нийт 96 хөтөлбөрөөс 21 хөтөлбөрийг чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрт шилжүүлэн боловсруулав. Дараагийн 3 жилийн хугацаанд НСТ-д ашиглаж байгаа хөтөлбөрүүдийг бүрэн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр болгох зорилт тавин ажиллаж байна.

#### **Онлайн сургалт, шалгалтын систем, тоног төхөөрөмж нэвтрүүлэлт:**

Зам, тээврийн салбарт 2021 оныг “Техник, технологийн шинэчлэл, цахим шилжилтийн жил” болгон зарласантай холбогдуулан НСТ нь цахим сургалтыг зохион байгуулах, орон зайнаас үл хамааран онлайн-суралцах нөхцөл бололцоог бүрдүүлэх зорилгоор “Онлайн сургалт, шалгалтын систем” боловсруулах ажлыг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Мэдээллийн аюулгүй байдал, технологийн албатай хамтран онлайн сургалт, шалгалтын системийг 6 дугаар сараас эхлэн <https://news.mcaa.gov.mn> хаягт байршуулан үйл ажиллагаанд ашиглаж байна. Уг системд 2022 онд дараах мэдээллүүдийг оруулж, ажилласан. Үүнд:

- 19 сургалтын хөтөлбөрийн 48 онлайн шалгалтыг 635 суралцагчаас авсан;
- 595 багш, суралцагчийн мэдээллийн оруулсан;
- 680 цахим номыг байршуулсан.



Нисэхийн сургалтын төвд 2022 онд зохион байгуулах дотоод сургалтын дэлгэрэнгүй төлөвлөгөөгөөр цахим каталог боловсруулж цахим хуудсанд байршуулсан ба эмхэтгэл хэлбэрээр хэвлүүлэн Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлийн гишүүдэд хүргүүлж, 2022 онд зохион байгуулагдах сургалтыг танилцуулсан. Мөн зохион байгуулагдсан 28 сургалтын мэдээлэл болон сургалтын үйл ажиллагаатай холбогдолтой 22 мэдээ, мэдээллийг боловсруулж, нэгжийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд нээлттэй болгов.

Нисэхийн сургалтын төв нь 2022 оны жилийн эцсийн байдлаар олон улсын түвшний дараах 2 сургалтыг амжилттай зохион байгуулан ажилласан. Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Тайландын Хаант Улсын иргэний нисэхийн сургалтын төвтэй хамтран “STP-052 Аэродромын нислэгийн удирдагч бэлтгэх сургалт”-ыг 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулан ажиллалаа. Сургалтад нийт 16 суралцагч суралцан, 15 төгсөгч гэрчилгээжив. Мөн сургалтыг амжилттай төгссөн 15 суралцагчаас 6 суралцагч Тайландын Хаант Улсын иргэний нисэхийн сургалтын төвд үргэлжлүүлэн Ойртолтын нислэгийн удирдагч бэлтгэх STP-053 сургалтад 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс суралцах бэлтгэл ажлыг хэрэгжүүлэн ажиллаж НСТ болон ТХУИНСТ хамтарсан нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа.
- ИНЕГ болон БНСУ-ын “Ханseo” их сургууль хоорондын “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдөр байгуулсан бөгөөд санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагааг амжилттай зохион байгуулан ажиллалаа. “Ханseo” их сургуульд нислэгийн удирдагч мэргэжлээр суралцаж байгаа 10 оюутныг “Ажлын байртай танилцах” үйлдвэрлэлийн дадлага сургалтад хамруулах ажлыг 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд зохион байгуулсан.

#### **Номын сангийн үйл ажиллагаа:**

Номын сангийн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагуудын сүүлийн үед хэрэгжүүлж байгаа чиг хандлага болон хэрэглэгчдэд шаардлагатай байгаа цахим ном, хэвлэлээр орон зай, цаг хугацаанаас үл хамааран үйлчлүүлэх боломжоор хангах, бие даан суралцах, мэдлэгээ дээшлүүлэхэд зориулж интернэтийн орчинд суурилсан дижитал номын сангийн үйлчилгээг 2022 онд шинээр нэвтрүүлэн ажилласан. Дижитал номын санд:

- Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын 401 ном, хэвлэл;
- Нисэхийн мэргэжлийн 235 ном хэвлэл;
- Бусад төрлийн 44 нийт 680 ном, хэвлэлийг бүртгэж оруулсан.

**Программ хангамж хөгжүүлэлтийн чиглэлээр:** “Цахим НААХЗА” системийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд:

1 дүгээр үе шатны 7 модулийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилтын хүрээнд:

- Тест- “Зохицуулалтын үйлчилгээний дэд систем”, “Хяналт, шалгалтын дэд систем”, “Гэрчилгээжсэн байгууллагаас ирүүлэх баримт бичгийн хяналт, баталгаажуулалтын дэд систем”, “Гадны хэрэглэгчийн үйлчилгээний дэд систем”, “Номын сан, гэрчилгээжсэн байгууллагын батлагдсан, хүлээн зөвшөөрөгдсөн журам, зааврын өгөгдлийн сангийн дэд систем”, “Хүний нөөцийн удирдлагын дэд систем”, “Архивын дэд систем”-үүдийн тестийг хийж гүйцэтгэсэн.
- Сайжруулалт- Дээрх дэд системүүдийн тестийн дараах хөгжүүлэлтийг хийсэн.
- Нэвтрүүлэлт- Системийн 1 дүгээр үе шатны 7 модулийг үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажилласан.
- Журам- Цахим НААХЗА системийн харилцан ажиллагааны журмын төслийг боловсруулан НААХЗА-ны байцаагч нараас санал аван нэгтгэсэн.
- 2 дугаар үе шатны 6 модулийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх зорилтын хүрээнд:
- Судалгаа- “Онцгой үүргийн болон тусгай нислэгийн зөвшөөрөл олгох дэд систем”, “Осол зөрчлийн мэдээлэл, дүн шинжилгээний дэд систем”, Хуралдаан, үүрэг даалгаврын дэд систем”, “ИКАО, USOAP-CMA, Annex-ын өөрчлөлт, CC-EFOD, PQ, CAP дэд систем”, “Албан хэрэг хөтлөлтийн дэд систем”, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дэд системүүдийн судалгааг хийсэн.





- Шинжилгээ- “Онцгой үүргийн болон тусгай нислэгийн зөвшөөрөл олгох дэд систем”, “Хуралдаан, үүрэг даалгаврын дэд систем”, “Албан хэрэг хөтлөлтийн дэд систем”, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дэд систем”-үүдийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.
- Хөгжүүлэлт- “Онцгой үүргийн болон тусгай нислэгийн зөвшөөрөл олгох дэд систем”, “Хуралдаан, үүрэг даалгаврын дэд систем”, “Албан хэрэг хөтлөлтийн дэд систем”, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дэд систем”-үүдийн хөгжүүлэлтийг хийсэн.
- Тест- “Хуралдаан, үүрэг даалгаврын дэд систем”, “Албан хэрэг хөтлөлтийн дэд систем”, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дэд систем”-үүдийн тест, туршилтыг НААХЗА-тай хамтран хийж гүйцэтгэсэн.
- Нэвтрүүлэлт- “Хуралдаан, үүрэг даалгаврын дэд систем”, “Албан хэрэг хөтлөлтийн дэд систем”, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дэд систем”-үүдийг үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг ханган ажилласан.

#### **Систем тоног төхөөрөмжүүдийн хүрээнд:**

Иргэний нисэхийн ерөнхий газар түүний харьяа алба салбар нэгжүүдийн хэмжээнд ашиглагдаж буй компьютеруудийг албан ёсны байнгын ашиглах эрх (лиценз)-тэй үйлдлийн систем болон оффисын программ хангамжтай болгох хүрээнд Active Directory DHCP, KMS серверүүд бэлдэн Active Directory domain service Infosolution ХХК-ны инженерүүдтэй хамтран суулгасан. Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд нийт 623 компьютер ашиглагдаж байгаагаас нийтийн сүлжээнд холбогдсон, нууцлалтай болон хязгаарлагдмал мэдээлэл дамжуулдаг хэрэглэгчдийн 75 компьютерыг лицензжүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжийн 51 удирдах албан тушаалтанд тоон гарын үсгийн гэрчилгээ үүсгүүлэн, тээгч төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн бөгөөд iMCAA системд албан бичгийн төслийг тоон гарын үсгээр баталгаажуулах боломжийг бүрдүүлсэн. Мөн баталгаажсан баримт, бичиг бүрийг QR коджуулах ажлыг судалж, хөгжүүлэлтийг хийсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын өнөөгийн байдал цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилго бүхий “AXF-Cyber security” форумыг “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудалд 2022 оны 6 дугаар сарын 09-ний өдөр амжилттай зохион байгуулсан. Форумар мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болон эрсдэлийг бууруулах чиглэлээр авах арга хэмжээний талаар хэлэлцсэн. ИНЕГ, ИНУТ-ийн газар, албадын удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүд, Тагнуулын ерөнхий газар, Мобиком корпораци, ШУТИС зэрэг байгууллагуудын нийт 105 хүн оролцсон.

#### **Архив, албан хэрэг хөтлөлт:**

Архивын үйл ажиллагаанд Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Архивын ажлыг эрхлэн хөтлөх заавар”, Үндэсний төв архивын даргын тушаалаар баталсан “Баримт бичиг хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалт” болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг мөрдөж ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвшөөрлийн хуудсаар Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа алба, салбарын ажилтнуудад 10 хадгаламжийн нэгж баримтыг түр ашиглуулахаар олгосон бол 6 ажилтанд цаасаар 255 хуудас баримтыг хуулбарлан лавлагаа гаргасан.

Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журмын 7-р зүйлийн 7.5, 7.5.4, 7.6, 7.8, 7.12 дэх заалтыг тус тус мөрдлөг болгож, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны Б/183 дугаар тушаалын дагуу Архивд хадгалагдаж байгаа нийт баримтыг тоолж, тооллогын тайланг нэгтгэн гаргаж, ажил хүлээлцэж дууссан. Тооллогын тайланг ажил хүлээлцэх комиссын дарга, нийт гишүүдэд танилцуулж, гарын үсэг зуруулсан.

Архивын баримтын эрэл хайлтыг шуурхай болгох, ашиглалтыг сайжруулах зорилгоор архивын бүртгэл, хайлтын програмд актаар хүлээлцсэн нийт 240 баримтыг 70 жил болон түр хадгалах дансны бүртгэлд бүртгэсэн.

Архивын ажлын зохион байгуулалтын хүрээнд түр хадгалалтын 10-р бүртгэлээс 9-р бүртгэлийн дансанд 682 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 6-р данснаас 5-р дансанд 47 хадгаламжийн нэгж тус тус он цагийн дарааллаар шилжүүлэх ажил хийгдсэн.

Архивт хүлээн авсан ЗУГ-ын 2020 оны Ирсэн бичгүүдэд нягтлан шалгалт хийж, 19 хадгаламжийн нэгж баримтад шинээр товъёог үйлдэж, техник засварын ажил хийсэн.

Баримт нягтлан шалгах комиссын ээлжит хурлыг хуралдуулах ажлын хүрээнд БНШК-ын хурлын төлөвлөгөөг боловсруулж, комиссын даргад хүргүүлсэн. БНШК-ын дүрмийн төслийг боловсруулж, комиссын даргаар хянуулж, хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болсон.



Тайлант хугацаанд нийт гаднын болон харьяа байгууллагад явуулсан 182 гадаад бичиг 10, дотоод явсан бичиг 6, тодорхойлолт 11 бичгийг бүртгэж, холбогдох байгууллагуудад цаг тухайд нь хүргүүлсэн.

Тайлант хугацаанд Иргэний нисэхийн ерөнхий газарт 232 албан бичиг ирснээс шийдвэрлэгдсэн 15, шийдвэрлэлтийн шатандаа 205, хугацаа хэтэрсэн 12 албан бичиг байна.

Үйл ажиллагааны чиглэлээр 30, боловсон хүчний чиглэлээр 28 тушаал гарсныг бүртгэн холбогдох зохион байгуулалтын нэгж, албан тушаалтнуудад тараасан.

Явсан албан бичиг болон А, Б тушаалуудыг iMcaa албан хэрэг хөтлөлтийн цахим бүртгэлийн программд скайнердан бүртгэн оруулж, шийдвэрлэлтийн хугацаа хэтэрсэн албан бичгийн мэдээг 7 хоног тутам гаргаж Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын шуурхайн зөвлөгөөнд танилцуулан, шийдвэрлэлтэд нь хяналт тавин ажиллаж байна.

### **ЗУРГАА. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ, ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Олон Улсын гэрээ хэлцэл боловсруулах, санамж бичиг байгуулах, хууль эрх зүйн холбоотой бусад баримт бичигт санал өгөх, Иргэний нисэхийн ерөнхий газрын удирдлага, ажилтнуудад эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгөх, боловсруулан гаргаж байгаа эрх зүйн баримт бичгийн үндэслэлийг хянаж хууль тогтоомжид нийцүүлэх, хэрэгжилтийг хангуулах, шүүхийн маргаантай асуудлаар шүүх, хууль хяналтын байгууллагад байгууллагаа төлөөлөн оролцох, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Хөдөлмөрийн маргаан таслах орон тооны бус комисс, Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллах, Чикагогийн Конвенцын Хавсралтын стандартын минимум суурь түвшнийг хангасан, Монгол Улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд тохирсон, хэрэгжүүлэх боломжтой, иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааны зохицуулалтын дүрэм, зөвлөмжийн цуврал, маягт болон бүртгэлийн дэвтрийг жишиг-дүрмийн дагуу боловсруулах, тогтмол шинэчлэх болон дүрмийн шаардлагаас чөлөөлсөн бүртгэлийг зарлахтай холбоотой ажлууд, зөвлөмжийн цуврал, маягт, бүртгэлийн дэвтэр, танилцуулга материал гаргаж салбарын хэрэглэгчдийг үнэн зөв эрх зүйн мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

#### **Ёс зүйн зөвлөлийн талаар:**

Иргэний нисэхийн ерөнхий газрын ёс зүйн зөвлөл нь Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн “Дүрэм, журам шинэчлэн батлах тухай” А/23 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтны ёс зүйн дүрэм”, Иргэний нисэхийн ерөнхий газрын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам”-ыг мөрдөж ажиллаж байна. ИНЕГ-ын ажилтнуудаас Ёс зүйн зөвлөлд 14 өргөдөл, гомдол ирүүлснийг бүртгэн авч, 4 гомдол мэдээллийг шийдвэрлэж, хариу өгсөн ба ёс зүйн зөрчил гаргасан 1 ажилтанд хариуцлага тооцсон.

#### **Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:**

Иргэний нисэхийн ерөнхий газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2022 онд хийх ажлын төлөвлөгөө”-г 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд:

“Гэмт хэргийн ойлголт”, “Зөвийг зөвлө”, “Шударга нийгмийн төлөө хамтдаа”, “Авлигатай тэмцэх газарт хэрхэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах вэ?”, 2021 онд батлагдсан “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль” болон 1995 оны “Хувь хүний нууцын тухай хууль”-ийг харьцуулсан мэдээлэх сургалтыг root@mcaa.gov.mn сайтаар цахим хэлбэрээр, “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, түүнээс урьдчилан сэргийлэх тухай”, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай ойлголт, Ажлын байрны бэлгийн дарамт, “Монгол Улсын зам тээврийн ослын нөхцөл байдал, замын хөдөлгөөнд соёлтой оролцох, хүүхдийг авто тээврийн хэрэгсэлд зөв тээвэрлэх, 2018 оны замын хөдөлгөөний шинэчилсэн дүрмийн холбогдох заалтын зохицуулалтын талаар, зам тээврийн ослын модуль сургалт”, “Хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, үр хүүхдээ хорт зуршлаас хэрхэн ангид байлгах вэ” сэдэвт сургалтыг танхимын хэлбэрээр тус тус зохион байгуулан ажилласан.

#### **Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын талаар:**

Хөдөлмөрийн тухай (шинэчилсэн найруулга) хууль 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/197 дугаар тушаалаар Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг 6 гишүүний бүрэлдэхүүнтэй дахин шинэчлэн байгуулснаас хойш 17 гомдол хүлээн авч хэлэлцсэн ба нийт 33 гомдлыг тайлант хугацаанд хэлэлцэж, тэмдэглэлийг албажуулсан байна.

**Авлигатай тэмцэх талаар:**

Авлигатай тэмцэх газраас хэрэг бүртгэлтийн мөрдөн шалгах ажиллагаа явуулахад холбоотой баримт бичгүүдийг хүлээн авч, бүртгэж, хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан байна. Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газраас 8 албан бичиг ирснээс хугацаатай 8 албан бичгийн хариуг цаг тухайд нь хүргүүлэн ажилласан.

Хуулийн этгээд, иргэнтэй нийт 36 гэрээ байгуулсан ба гэрээний мэдээллийг Иргэний нисэхийн ерөнхий газрын <https://www.mcaa.gov.mn/> цахим хуудасны Ил тод байдал-Шилэн данс-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газар -Бусад- “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл” хэсэгт сар бүрийн 05-ны өдрийн дотор байршуулан ажилласан байна.

**Хөдөлмөрийн дотоод журам, Хамтын гэрээний талаар:**

Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан хуульд нийцүүлэн Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”, “Хөдөлмөрийн гэрээ”-г шинэчлэн боловсруулж, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/05 дугаар тушаалаар шинэчлэн батлуулсан. Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмыг Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар нэгжийн ажилтнуудад танилцуулга-сургалт зохион байгуулсан. Мөн Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/270 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, мөрдөн ажиллаж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/36 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу “Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа байгууллагуудад 2020-2021 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ”-г ажил олгогч, ажилтны төлөөлөгчид хамтран 88.8 хувьтай дүгнэж, “ИНЕГ, түүний харьяа байгууллагуудад 2022-2024 онд хэрэгжүүлэх хамтын гэрээ”-г ажил олгогч болон ажилтны төлөөлөгч болох Монголын тээвэр холбоо, газрын тосны Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтран 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан. Хан-Уул дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдөр бүртгүүлсэн.

**ДОЛОО. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР**

2022 оны улсын төсөвт төвлөрүүлэх навигацийн орлогыг сарын хуваарийн дагуу 150.0 тэрбум төвлөрүүлэхээс 2022 оны 11 дүгээр сарын 30-ний байдлаар 16.0 тэрбум төгрөг сарын хуваарийн дагуу төвлөрүүлсэн бөгөөд гүйцэтгэл 10.7 хувьтай байна. 12 дугаар сард орлого төвлөрүүлэх хуваарийн дагуу болон хүлээгдэж буй гүйцэтгэл байхгүй.

**2022 оны үйл ажиллагааны төсөө боловсруулан нэгтгэж, батлуулах талаар:**

- Иргэний нисэхийн ерөнхий газар, харьяа алба, салбарын тухайн жилийн төсвийн хязгаар, төсвийн төсөл, дараа жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг орлого, зардлын үзүүлэлт бүрээр нэгтгэн хянаж, Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яаманд хугацаанд нь хүргүүлсэн.
- Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн А/17/16 дугаар тушаалаар орлогын төлөвлөгөөг 308,965.3 сая төгрөгөөр, зардлыг 158,965.3 сая төгрөгөөр баталсан.
- 2022 оны орлого, зарлагын төлөвлөгөө болон өөрийн орлогоос санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн батлуулах саналыг хүргүүлснээр 2022 оны 10 дугаар сарын 31-ны А/286/218 дугаар Сангийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайдын хамтарсан тушаалаар шинэчлэн баталсан. Үүнд орлогын төлөвлөгөөг 304,955.3 сая төгрөг ба өөрийн орлогоос санхүүжих хөрөнгө оруулалтын зардлыг 5,527.1 сая төгрөгөөр бууруулж, урсгал зардлыг 1,517.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зардлын төлөвлөгөөг 154,955.3 сая төгрөгөөр баталсан.

**Санхүүгийн бүртгэл, тайлан гаргах талаар**

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2021 оны жилийн эцэс, 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланг хугацаанд нь гарган Зам, тээврийн хөгжлийн яам, Сангийн яам, Татварын ерөнхий газар, Үндэсний Аудитын газарт хүргүүлж баталгаажуулан байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулан нийтэд ил тодоор тайлагнан ажилласан.



2022 онд Иргэний нисэхийн ерөнхий газар /агентлаг/ нийгмийн даатгалын шимтгэлд 807.0 сая төгрөг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 285.8 сая төгрөг, Нэмэгдсэн өртгийн албан татварт 252.1 сая төгрөг, Хувь хүний орлогын албан татварт 39.9 сая төгрөг, Үл хөдлөх хөрөнгийн болон газрын албан татварт 3,665.6 сая төгрөг тус тус төвлөрүүлж улсын болон орон нутгийн төсөвт нийт 5050.4 сая төгрөгийг төвлөрүүлээд байна.

**Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт:**

- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/85 дугаар тушаалаар томилогдсон эд хөрөнгийн хяналтын тооллого хийх 16 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдаж 2022 оны 5 дугаар сарын 02-ны өдрөөс 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн хооронд батлагдсан удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Тооллогоор төвийн салбарын хөрөнгүүдийг тоолсон бөгөөд тооллогын явцад алба салбаруудын хооронд шилжсэн хөрөнгийн нэгдсэн жагсаалт гарган шийдвэр гаргуулж шилжилт хөдөлгөөнийг хийж, ГТҮШХА-нд Хятад улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар ирсэн 8 тээврийн хэрэгслийг дагалдаж ирсэн 416 ш сэлбэгийг үнэлж Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар оруулан бүртгэлд тусгасан.
- Улсын үзлэг тооллого хийгдэж байгаатай холбогдуулан ТӨБЗГ-г программд хөрөнгийн бүртгэлийг нэг бүрчлэн оруулж нэгтгэсэн байдлаар 2,109,631.88 сая төгрөгийн хөрөнгийг шивж оруулсан байна.
- Иргэний нисэхийн ерөнхий газрын системийн хэмжээнд 2021 оны жилийн эцэс болон 2022 оны эхний хагас жилийн байдлаар 3,453.73 сая төгрөгийн өртөгтэй 1,292 ширхэг үндсэн хөрөнгийг актлуулах саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2022 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн №01/1581 дүгээр албан бичиг хүргүүлсэн.
- Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2022 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн №02 дугаар шийдвэрийн дагуу өртгөөрөө элэгдлээ нөхсөн 15,017 ширхэг 78,844.07 сая төгрөгийн хөрөнгийг 23,121.32 сая төгрөгөөр үнэлж бүртгэлд тусгуулахаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2022 оны 9 дүгээр сарын 08-ны өдрийн №01/1580 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
- Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 2022 оны 10 сарын 03-ны өдрийн №01/1733 дугаар албан бичгээр МИАТ-ын шатахуун түгээх станцын зориулалттай 59.6 м2 газар, 2022 оны 9-р сарын 30-ны өдрийн №01/1720 дугаар албан бичгээр ХУД-ийн 8-р хорооны Жаргалантын аманд байрлах 7.9 га газрыг бүртгэлд тусгуулахаар тус тус албан бичгээр хүргүүлсэн.

**Агаарын тээвэрлэгчдийн авлага барагдуулах талаар:**

Иргэний нисэхийн ерөнхий газар түүний харьяа салбар, нэгжүүдийн 2021 оны авлагын эцсийн үлдэгдэл 32.2 тэрбум төгрөг, 11 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 29.04 тэрбум төгрөг болж 15 хувиар буурсан байна. Нийт авлагын 58 хувийг гадаадын агаарын тээвэрлэгчдээс авах авлага, 36 хувийг дотоодын агаарын тээвэрлэгчдээс авах авлага, 1 хувийг бараа материалын худалдан авалттай холбоотой авлага, 1 хувийг гадаадад суралцагсдын авлага эзэлж байна. Үүнээс:

Гадаадын агаарын тээвэрлэгчдээс авах авлага (агаарын навигацийн үйлчилгээний авлага) 2021 оны жилийн эцсийн үлдэгдэл 22.4 тэрбум төгрөг байсан бол 2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 16.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй буюу 27.2 хувиар буурсан байна.

Гадаадын 15 агаарын тээвэрлэгчдийн нийт 1,818,4 мянган ам.долларын авлагаас Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 тушаалаар дампуурсан, тухайн улсын шүүхийн шийдвэр нь гарсан Air Ukraine, Austrian Airlines, Jade Cargo International зэрэг 3 компанийн 100.3 мянган ам доллар буюу 285.9 сая төгрөгийн тус тус авлагыг данснаас хассан.

2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар үлдсэн 12 (Иргэний нисэхийн ерөнхий газрын нийт авлагын 83.6 хувийг эзэлж буй) гадаадын агаарын тээвэрлэгчдээс авах авлагын 16.3 тэрбум төгрөгөөс хугацаандаа байгаа авлага 10.5 тэрбум төгрөг ба он удаан жил дамжсан найдваргүй авлага 1.7 сая ам.доллар буюу 5.7 тэрбум төгрөг байна. Үүнээс 3 компанийн 1,135.4 мянган ам.долларын (64.7%) авлагатай холбоотой тухайн улсын шүүхийн шийдвэр ирсэн бөгөөд материалыг бүрдүүлж /орчуулах/ Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлөөр шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

Дансны авлагын удирдлагыг сайжруулж, өр авлагын хэмжээг бууруулах, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулан өр төлбөр, авлагыг бууруулах төлөвлөгөөтэй ажилласны үр дүнд тайлант онд гадаадын агаарын тээвэрлэгчдийн авлага нэмэгдээгүй ба урд оны мөн үеийнхтэй харьцуулахад (2021 оны 10 дугаар сарын 31-ний авлагыг 2022 оны 10 дугаар сарын 31) 9,336.7 сая төгрөг буюу 47 хувиар буурсан байна.

Дотоодын агаарын тээвэрлэгчдийн авлага системийн хэмжээнд оны эхний үлдэгдэл 9.3 тэрбум төгрөг байсан бол 2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 10.6 тэрбум төгрөгт хүрч 1.3



тэрбум төгрөг буюу 14% хувиар өссөн байна.

### ***Шилэн дансны хуулийн хэрэгжилт***

Агентлаг 2022 оны батлагдсан төсвийг 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр шилэн дансанд байршуулсан.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн А/17/16 дугаар хамтарсан тушаалаар "Иргэний нисэхийн үндэсний төвийн 2022 оны орлого, зарлагын төлөвлөгөө" батлагдсан. Шилэн дансанд 2022 оны төсвийг байршуулсан.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд сар бүрийн 07-ны дотор мэдээлж байна. 2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар орлогын 221,503.8 сая төгрөгийн 710 ширхэг мэдээлэл, зарлагын 207,586.2 сая төгрөгийн 159 ширхэг мэдээлэл, нийт 429,090.0 сая төгрөгийн 869 ширхэг мэдээлэл байршуулсан.

Сар бүр хуулийн хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг тогтмол байршуулж байна. 2022 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 51 аж ахуйн нэгжийн 34,460.6 сая төгрөгийн санхүүжилтийг хийж, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, компаниудын нэр, хаягийг байршуулсан.

### ***Хөрөнгө оруулалтын талаар:***

Иргэний нисэхийн ерөнхий газрын өөрийн орлого болон цэвэр ашиг, урсгал зардлаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, ИНЕГ-ын 2022 оны бараа ажил, үйлчилгээ худалдан авалтын биелэлтийн мэдээллийг шилэн дансанд байршуулан ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад хяналт тавьж нийт 5,912.8 сая төгрөгийн санхүүжүүлэлт мөн 2022 оны 11-р сарын 18-ны байдлаар гэрээнд заасан баталгаат хугацаа дууссан 37 компанийн 778.6 сая төгрөгийн барьцааг чөлөөлж төлбөрийг тус тус олгосон байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын 2022 оны өөрийн орлогоос санхүүжих 16.4 тэрбум төгрөгийн 45 төсөл, арга хэмжээ батлагдсан.

- ✓ Үүнээс он дамжин хэрэгжүүлж байгаа 13 төсөл, арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 6, ажил гүйцэтгэж байгаа 7 төсөл, арга хэмжээ байна. Бүрэн хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнүүдийг 3,356.30 сая төгрөгөөр санхүүжүүлээд байна.
- ✓ Шинээр хэрэгжүүлэх 32 төсөл, арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 1 төсөл, арга хэмжээг 1,421.55 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна.

## **НАЙМ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

### ***Хяналт-шинжилгээний талаар:***

Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 2022 оны 06 дугаар сараас Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын шуурхай зөвлөгөөн болон өргөтгөсөн шуурхай зөвлөгөөний хэрэгжилтийг 14 хоног тутам газрын даргад танилцуулж, сар бүр Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалын хэрэгжилтийн товч тайлан, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга болон Зам, тээврийн хөгжлийн сайдын албан даалгаврын үнэлгээ, улирал бүр хууль тогтоомж, тогтоол шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн биелэлт, Сайдын тушаал болон Сайдын зөвлөлийн хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг хагас жилээр Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулж, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн А/93 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор "Иргэний нисэхийн ерөнхий газрын төсвийн хэмнэлт, нэмэлт орлого олох төлөвлөгөө"-г боловсруулж, 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 02/609 тоот албан бичгээр Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлсэн.

"Хүний хөгжил, судалгаа, сургалтын төв" ТББ-ын "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын хэрэгжилтэд хийсэн хөндлөнгийн үнэлгээний тайланг Даргын зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 11-нд болсон 2 дугаар хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулж, тайланг 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авсан.

### ***Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:***

ИНЕГ болон түүний харьяа салбар, нэгжүүдийн шилэн дансны цахим хуудсыг сар бүр хянаж, зөрүүтэй мэдээллийг тухай бүрд нь залруулах арга хэмжээ авч байна. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх, хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох, хууль, журмын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгч зөрчлийг арилгах, засаж залруулах зорилгоор улирал



бүр аудит хийж хэвшсэн. Мэдээллийн нэгдсэн тайланг улирал бүрийн дараа сарын 15-ны дотор Зам, тээврийн хөгжлийн яаманд хүргүүлж байна.

**Авлигын эсрэг хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:**

Авлигын эсрэг хээлийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж, 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Авилгатай тэмцэх газарт тогтоосон хугацаанд хүргүүлж, гүйцэтгэлийг Авилгатай тэмцэх газрын цахим системд 2022 оны 01, 07 дугаар сард 2 удаа оруулсан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 85%-тай байна.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн салбарт авлигын индексийг бууруулах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд авлигад өртөх магадлал бүхий албан тушаалын жагсаалтыг албан хаагчдын дунд судалгаа явуулж, тодорхойлон, зөвлөмж зөвлөгөө боловсруулж, нийт 88 ажилтнуудаас санал асуулга авч, нийтийн албан тушаалтны баримтлах зарчим, ашиг сонирхлын зөрчлийг хэрхэн зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх өндөр магадлалтай үйл ажиллагааг хориглох буюу хязгаарлах талаарх зөвлөмжийг 165 албан тушаалтанд цахимаар хүргүүлсэн.

Иргэний нисэхийн ерөнхий газрын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны нэрсийн жагсаалтыг шинэчлэн Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар батлуулж, Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжийн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын 2021 оны ХАСХОМ-ийг 147 ажилтнаас хуулийн хугацаанд гаргуулан авч, тайлан мэдээг Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн. Мөн 2022 оны эхний 11 дүгээр сарын байдлаар ажилд томилогдсон 72 ажилтнаас ХАСХОМ-ийг 30 хоногийн дотор гаргуулан авсан.

Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийг шинэчлэн, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/59 дүгээр тушаалаар батлуулсан. Энэхүү тушаалтай холбогдуулан ажил олгогчийг төлөөлж ажилтнуудтай хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсгэж, ажилд авах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг болон албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, хянах, баталгаажуулах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг гаргаж Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны А/60 дугаар тушаалаар батлуулсан.

Худалдан авах ажиллагаанд 2022 оны 01 дүгээр сараас 10 дугаар сарын хооронд оролцсон албан тушаалтнуудын гаргасан 292 мэдэгдэл, тайлбарыг Авилгатай тэмцэх газрын мэдээллийн системд оруулсан. Үнэлгээний хороог томилсон Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга болон Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын тушаалыг нягтлан, мэдэгдэл, тайлбарыг тулгаж, орхигдуулсан тушаалуудыг нөхөж оруулахаар холбогдох арга хэмжээ авч байна.

**ДҮГНЭЛТ:**

Төрөөс иргэний нисэхийн талаар баримтлах бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулж, хууль тогтоомжийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээг авч Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР